

ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2022 оны 10 сарын 05-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 09 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн ээлжит 4 дүгээр Хуралдаанаар аймгийн ИТХ-ын 11 дүгээр Хуралдааны тов, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 29 дүгээр захирамжаар 8 асуудал хэлэлцэхээр батлав.

Аймгийн ИТХ-ын XI Хуралдаан 2022 оны 09-р сарын 08-ны өдөр 87.8 хувийн ирцтэй хуралдаж, үндсэн 8, нэмэлтээр 1 нийт 9 асуудал хэлэлцэж 9 тогтоол баталлаа.

Аймгийн ИТХ-ын XI Хуралдаанаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Арваннэгдүгээр Хуралдаанаар:

- 1.Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц
- 2.Аймгийн ИТХ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тухай /2022 оны эхний хагас жилийн байдлаар/
- 3.Төв аймгийн Сүмбэр сум, Сэлэнгэ аймгийн Баянгол сумтай хиллэдэг хилийн цэсэд өөрчлөлт оруулах санал уламжлах тухай
- 4.Сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай
- 5.Мөнгөнморьт сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай
- 6.Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл уламжлах тухай
7. Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн 2 гишүүнийг чөлөөлөх тухай
- 8.Аймгийн Сонгуулийн хороог татан буулгах тухай
- 9.Энгийн болон аюултай хог хаягдлын төвлөрсөн эко байгууламж барих зорилгоор Сэргэлэн сумын зарим газрыг улсын тусгай хэрэгцээнд авах санал уламжлах тухай асуудлыг нэмж нийт 9 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 9 тогтоол баталлаа.

Энэ сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 22 албан бичиг ирснээс хариу өгөх шаардлагатай 11 бичгээс 9 албан бичгийн хариуг хүргүүлж, хариу хүргүүлэх шаардлагатай 2 албан бичиг шийдвэрлэх шатандаа байна.

Аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас Ерөнхийлөгчийн Тамгын газар, салбарын яамдуудад болон холбогдох албан байгууллагад 29 албан бичиг гарган хүргүүлсэн. Энэ сард 4 өргөдөл бүртгэгдсэнээс 1 нь шийдвэрлэгдэж, 3 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.

09-р сарын 07-ны өдөр “Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын хүрээнд “Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээ зохион байгуулж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааг 2 дахин бууруулах, санал хүсэлт хүлээн авах сувгийг нэмэгдүүлэх зорилгоор Дэлгэрхаан, Мөнгөнморьт сумдын иргэдтэй аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма нар цахим уулзалт хийлээ.

Тус уулзалтаар сумдын цэцэрлэг, сургуулийн их засвар, тэгш ой тохиож буй сумдын хөрөнгө оруулалтын талаар, өвс тэжээлийн хангалт, нүхэн жорлонгийн хөрсний болон ахуйн бохирдол, эрүүл мэндийн салбарын эм хангалтын асуудал зэрэг хэд хэдэн төрлийн асуудал дэвшүүлж, удирдлагууд иргэдээс гарсан асуудлыг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээнүүдийг авахаа илэрхийллээ.

Аймгийн ИТХ-ын Газрын харилцаа, байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороо 2022 оны 09-р сарын 09-өөс 11-ний өдрүүдэд уул уурхай, газар тариалан бүхий Борнуур, Жаргалант, Заамар, Цээл, Угтаацайдам сумдад ажиллалаа. Энэ үеэр аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, Ургацын урьдчилсан баланс, ургац хураалтын үйл явц, 2022 оны МАА-н өвөлжитийн бэлтгэл байдал, Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын явц, Уул уурхайн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, Нөхөн сэргээлтийн ажлуудтай танилцав.

Заамар суманд хариуцлагатай уул уурхайг дэмжих “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд ААН-д эзэнгүй орхигдсон талбайд хийж буй биологийн нөхөн сэргээлтийн

ажилтай тус тус танилцаж, эдгээр сумдад ажил эрчимжүүлэх, хурлын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөн тусалж, чиглэл өгчээ.

Төв аймгийн ИТХ болон Бүгд найрамдах Солонгос Улсын бие даасан Чезү хотын ИТХ хооронд 2017 онд байгуулсан хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийн хүрээнд Төв аймгийн ИТХ-ын даргын урилгаар Чезү хотын ИТХ-ын дарга Ким Кён Хак болон, албаны төлөөлөгчид Төв аймагт 2022 оны 09-р сарын 1-2-ны өдрүүдэд албан айлчлал хийлээ.

Чезү хотын ИТХ-ын дарга Ким Кён Хак болон, төлөөлөгчид хүсэлтийг хүлээн авч, судлан хариу мэдэгдэхээ илэрхийллээ. Мөн айлчлалын үеэр зочид төлөөлөгчдөд монгол орны байгаль, ёс заншил, өв уламжлал, эрийн гурван наадмыг сонирхууллаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр жил бүрийн 9-р сарын 10-ны өдөр тохиож буйтай холбогдуулан Цагаатгах ажлын зохион байгуулах аймгийн салбар комиссоос Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын "Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдрийг хүндэтгэн өнгөрүүлэх тухай" 2022 оны 10 дугаар захирамжаар батлагдсан төлөвлөгөөний дагуу Төв аймгийн салбар комиссоос дараах ажлуудыг зохион байгууллаа.

Хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хийгдсэн нэвтрүүлэг, тв контент зэрэг дүрс нэвтрүүлгийг олон нийтийн ТВ-ээр нэвтрүүлэх, олны хүртээл болгох ажлын хүрээнд:

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын бэлтгэсэн ярилцлага /3/, шторк /2/, нэвтрүүлэг /1/-ийг тус тус facebook болон аймгийн Төв, TBS телевизүүдээр нэвтрүүлж, аймгийн ИТХ-ын цахим хуудсанд байршуулсан. Мөн Төв аймгийн салбар комиссоос 6 мин 20 сек-ын телевизийн нэвтрүүлэг хийж, аймгийн Төв, TBS телевизүүдээр нэвтрүүлсэн нь 1000 гаруй хүн, аймгийн ИТХ-ын цахим хуудсанд байршуулан олон нийтийн хүртээл болгосон нь нийт 300 гаруй хүн тус тус үзсэн байна.

Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэж 09 сарын 10-ны өдөр авто машины гэрлийг асааж замын хөдөлгөөнд оролцуулах талаар цахим сүлжээгээр иргэдэд уриалга гарган, Төв аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт албан бичиг хүргүүлэв.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн даргын "Сургалт зохион байгуулах тухай" 2022.08.26-ны өдрийн А/11 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ИТХ-ын Ажлын албанаас ЕБС-ийн ахлах ангийн болон МСҮТ-ийн 1, 2 дугаар ангийн суралцагчдад “Монголд гарсан улс төрийн хэлмэгдүүлэлт: Дүгнэлт, сургамж” сэдвийн хүрээнд лекц уншиж, 90 гаруй хүүхэд хамрууллаа.

Хэлмэгдэгчдийн гэгээн дурсгалыг хүндэтгэж буяны ном хурах ажлыг Төв аймгийн Зуунмод суманд байрлалтай Дашчойнхорлон хийдэд зохион байгуулав.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд:

Аймгийн ИТХ-ын дэргэдэх “Иргэний зөвлөл” нь Зуунмод сумын 6 багийн 120 гаруй иргэдээс болон аймгийн Цагдаагийн газрын дэргэд үйлчилгээ авч буй 30 гаруй иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан байна.

Иргэний зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Цагдаагийн байгууллагын 2022 оны 1, 2-р улирлын үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийж, аймгийн Цагдаагийн газарт холбогдох зөвлөмж хүргүүлжээ.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар “Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явцыг 2022 оны 07 сарын байдлаар хэлэлцүүлэн Хурлын 2022 оны 09 сарын 08-ны өдрийн XI хуралдааны 01 дүгээр тогтоолоор 72,16 хувьтай дүгнүүллээ.

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 09 сарын 12, 26-ны өдрүүдэд танхимаар 2 удаа зохион байгуулж, тэмдэглэлээр 49 заалт бүхий үүргийг холбогдох байгууллага, суманд хүргүүлж, хэрэгжилт тооцов.

ЗГ-ын Иргэд олон нийттэй харилцах 1111 төвд 09 сарын 30-ний байдлаар 193 санал, хүсэлт, гомдол талархал ирсний 166-ийг шийдвэрлэн иргэнд хариу өгсөн бол 27 нь судлагдах шатандаа байна.

“Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д туссаны дагуу 09 сарын 07-ны өдөр “Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээг цахим болон танхимаар зохион байгууллаа. 2023 онд тэгш ой тохиох сумдын иргэдийн санал хүсэлтийг цахимаар, аймгийн төв буюу Зуунмод сумын иргэдийн санал хүсэлтийг аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүлээн авлаа.

Аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн Дэлгэрхаан, ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма Мөнгөнморьт, аймгийн Засаг даргын орлогч Ц.Буманбуян Эрдэнэсант, аймгийн ЗДТГ-ын дарга М.Отгонбат Баянжаргалан, аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга С.Магнайбаяр Баян-Өнжүүл, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэ Баяндэлгэр сумын иргэдийн санал хүсэлтийг цахимаар хүлээн авч 2023 оны бодлогын баримт бичигт тусгах, шалган туслах ажил зохион байгуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг үе шаттай зохион байгуулж байна.

Мөнгөнморьт, Баян-өнжүүл сумдын үйл ажиллагаанд Аймгийн засаг даргын баталсан удирдамжаар аймгийн ЗДТГ-ын бодлогын 6 хэлтсийн мэргэжилтнүүд оролцсон ажлын хэсэг тусгай удирдамжаар шалган туслах ажил хийж, албан бичгээр ажил эрчимжүүлэх үүрэг даалгавар өгч ажиллав.

9-р сард Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааныг 2 удаа хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажилласан. Уг 2 удаагийн хуралдаанаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 64 иргэний тодорхойлолтыг хэлэлцүүлж, холбогдох байгууллагаас дүгнэлт авч дээд шатны байгууллагад уламжилсан.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан 2 удаа хуралдаж 13 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн барих 6 асуудлыг холбогдох бодлогын хэлтсүүдээс авч өргөн барисан.

9-р сарын 6-ны өдөр Япон Улсын Тоттори муж, Төв аймгийн найрамдалт харилцаа байгуулсаны 25 жилийн ойн баярын бэлтгэл ажлын хурлыг цахимаар зохион байгуулж, Засаг даргын орлогч Ц.Буманбуян оролцов.

9-р сарын 11-18-ны өдрүүдэд Япон Улсын Тоттори мужийн Газар тариалангийн хүрээлэнгийн Судалгааны албаны дарга Шираива Нобутака Төв аймгийн Зуунмод, Борнуур, Батсүмбэр, Баянчандмань сумдуудад ажиллаж газар тариалан эрхлэгч нарт сургалт, зөвлөгөө зохион байгууллаа.

9-р сарын 15-17-ний өдрүүдэд БНСУ-ын Пёнтек хотын захирагч Жон Жансон болон бусад албаны хүмүүс Төв аймагт хүрэлцэн ирж БНСУ-ын Пёнтек хотын хөрөнгө оруулалтаар засвар шинэчлэлтийн ажил хийгдсэн Төв аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, цаашдын хамтын ажиллагааны талаар аймгийн удирдлагуудтай санал солилцов.

9-р сарын 27-ны өдөр Зүүн хойд Азийн Засаг захиргааны дээд хэмжээний 26 дахь удаагийн Саммит-ын бэлтгэл ажлын хурал БНХАУ-ын Жилин мужид цахимаар зохион байгуулагдаж, Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга М.Отгонбат, ТЗУХ-ын дарга С.Магнайбаяр, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Хишигдолгор нар оролцлоо.

2023 онд 100 жилийн ойгоо тэмдэглэх 6 сумын Засаг даргын мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ажил эрчимжүүлэх чиглэлээр үүрэг чиглэл өгөв.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХҮРЭЭНД

1. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:



1.1. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Төв аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний нутгийн захиргааны байгууллагууд, Эрдэнэ, Сэргэлэн сумдад “Чадахуйн зарчмын хэрэгжилт” сэдвээр хүний нөөцийн аудитыг 2022 оны 9 дүгээр сарын 19-нөөс 28-ны өдрүүдэд хийлээ.

- Аудитын багийг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн С.Цэдэндамба ахалж, ТАЗ-ийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газар; Сонгон шалгаруулалтын газар; Сургалт судалгаа, мэдээллийн сангийн газрын төлөөлөл бүхий 10 гишүүн чиг үүргийн дагуу ажиллаж Төрийн бүтээмжийн сэргэлт, төрийн албаны шинэтгэл, хүний нөөцийн менежмент, төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр арга зүйн дэмжлэг үзүүлсэн юм. Аудитын дүгнэлт 2022 оны 11 дүгээр гарна.

- Аудитын хүрээнд зохион байгуулагдсан дэд ажлуудаас танилцуулба:

• Аудитын зорилго, зорилттой холбоотой мэдээллийг Аймгийн Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага 70 албан хаагчид танилцуулсан.

- Аймгийн Үйлчилгээний Нэгдсэн төвийн үйл ажиллагаатай танилцаж, зарим албан хаагчдын санал, хүсэлтийг сонслоо.

- "Төрийн албаны хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт", "Шинэ сэргэлтийн бодлого-Төрийн бүтээмж" болон заримын шинэчлэн боловсруулж буй зарим журмын төслийн хэлэлцүүлгийг 23 байгууллагын 200 гаруй албан хаагчдын дунд зохион байгууллаа. (Аудитад хамрагдсан байгууллага, төрийн үйлчилгээний байгууллагууд, Зуунмод сумын ЗДТГ)

1.2. Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Баян-Өнжүүл суманд ажиллаж, удирдамжид тусгасан "Төрийн байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үнэлгээ, дүгнэлт, сахилга хариуцлагыг сайжруулах, ёс зүйн хэм хэмжээг бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн", "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах болон мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн" гэсэн 2 үзүүлэлтийн хүрээнд шалган тусаллаа.

1.3. Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 75 тогтоол гаргасан бөгөөд дундажаар 94.53%-ийн биелэлттэй байна.

1.4. Салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдол, СЗ-өөс явуулсан хариутай бичгийн шийдвэрлэлтийг танилцуулбал:

№	Төрөл	Нийт тоо	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Ирсэн албан бичиг	232	160	152	8	95.00%
2	Ирсэн өргөдөл, гомдол	14		14	0	100%
3	Явсан албан бичиг	130	121	108	13	89.25%

1.5. 27 сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны 7 албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах саналыг ТАЗ-д хүргүүлсэн.

2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:

2.1.Төв аймгийн ШШГГ-т шинээр томилогдон ажиллаж байгаа 9 албан хаагчидтай төрийн алба, албан хаагчийн ёс зүй, харилцаа, албаны онцлог, ахмад үеийн арга туршлагыг солилцох "Залгамж" уулзалт зохион байгуулагдсан бөгөөд Тус уулзалтад ТАЗСЗ-ийн Нарийн бичгийн дарга Г.Мөнхгэрэл оролцож төрийн албаны нэр хүнд, албан хаагчийн ёс зүй, харилцаанд анхаарах асуудлаар ярилцлага хийсэн.

2.2. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академийн захирал, доктор Д.Сүрэнчимэгийн "Бид хэрхэн ажилладаг вэ?" сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлага, албан хаагчид хамрагдлаа. Сургалтаар хувь хүний оюун бодол, хандлага, бидэнд ямар дадал үүсгэж, ажиллах арга барилд хэрхэн нөлөөлдөг, түүнийг өөрчлөх, сайжруулахын тулд юунд анхаарах, төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээ бодит нөхцөл байдалтай хэрхэн нийцдэг зэрэг олон талын мэдлэг олгох сургалтыг оролцоонд суурилсан аргаар зохион байгуулагдав.

2.3. "Төрийн албаны хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт", "Шинэ сэргэлтийн бодлого-Төрийн бүтээмж" болон заримын шинэчлэн боловсруулж буй зарим журмын төслийн хэлэлцүүлгийг 23 байгууллагын 200 гаруй албан хаагчдын дунд зохион байгууллаа.

3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр:

3.1. Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлөөс 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан тусгай шалгалтын нийлбэр дүнгээр төрийн захиргааны 32 ажлын байр нөхөгдөх боломжтой болж, нэр дэвшүүлэх ажиллагаа хийгдсэн.

Тус салбар зөвлөлөөс 2022 оны 09 дүгээр сарын өссөн дүнгээр 257 сул ажлын байрыг нөхөх тусгай шалгалтыг 6 удаа зохион байгуулахад 120 буюу нийт зарлагдсан ажлын байрны 46.7% нь нөхөгдсөн байна.

3.2. Төрийн албаны нөөц бүрдүүлэх Ерөнхий шалгалтын цахим бүртгэл 2022.08.25-аас 2022.09.25-ны хооронд явагдлаа. Энэ хугацаанд тус шалгалтыг Төв аймагт өгөхөөр 152 иргэн бүртгүүлээ.

3.3. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.6-д заасны дагуу төрийн захиргааны удирдах 2 (ахлах түшмэл), гүйцэтгэх 134 (дэс түшмэл-114, туслах түшмэл-20), нийт 136 сул орон тоог; Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 2.1, 2.2-д тус тус заасны дагуу төрийн үйлчилгээний байгууллагын 7 төсвийн шууд захирагчийн сул орон тоог тусгай шалгалтаар нөхөх захиалгыг ТА3-д хүргүүлээд байна.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

2022 оны 09 дүгээр сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **15** байгууллага **500 гаруй** төрлийн үйлчилгээг **4960** иргэнд, өдөрт дунджаар **200-250** иргэнд хүргэн үйлчилсэн байна.

Тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем /E-mongolia/-ийг нэвтрүүлсэн бөгөөд тус системээр дамжуулан 09 сард аймгийн хэмжээнд **830** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **492** лавлагаа үйлчилгээ авчээ.

Харин Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **6** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан, одоогийн байдлаар шийдвэрлэх хугацаа болоогүй **6** гомдол байна.

Байгууллагын цахим мэдээллийн буланд байх ухаалаг дэлгэцүүдээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт **165** иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан **31** иргэн машины татвар, торгууль төлөх, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авчээ.

Мөн энэ сард Үйлчилгээний нэгдсэн төвд “Зуунмод цэцэрлэгжүүлэлт” ОНӨААТҮГ-ын “Цэцгэнд умбасан Зуунмод” нээлттэй өдөрлөг болж **50** гаруй иргэн хамрагдсан бол Монгол Улсын төрийн албаны зөвлөлөөс энэ сард ирж байгууллагын үйл ажиллагаатай танилцаж санал зөвлөмж өгч ажилласан.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Аймгийн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, Гамшгийн үеийн стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, бие бүрэлдэхүүний албаны мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадвар, бие бялдрын шалгуур үзүүлэлтийг хангуулах зорилго бүхий 2022 оны сургуулийн жилийн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж 2022 оны сургуулийн жилийн эхний хагас 2-р үеийн сургалтын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хувиарын дагуу хичээл сургалт зохион байгуулагдаж байна.

Онцгой байдлын ерөнхий газартай хамтарч шинээр байгуулагдаж байгаа анги салбарын хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор Эрдэнэ суманд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан.

Монгол улсын шадар сайдын баталсан нэгдсэн хуваарь, удирдамжийн хүрээнд “Уул, уурхай баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нар гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллалаа. Шалгалтад Төв аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Уул, уурхай баяжуулах үйлдвэрийн 3 байгууллага хамрагдсанаас гал түймэр гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 24-н зөрчил илэрснийг цаг хугацаа шаардагдах 11 зөрчилд үүрэг өгөв.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан нэгдсэн хуваарь, удирдамжийн хүрээнд Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нар гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтад Төв аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн 7 байгууллага хамрагдсанаас гал түймэр гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 32-н зөрчил илэрснийг цаг хугацаа шаардагдах 1 зөрчилд үүрэг өгөв.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 16 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 137 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 72 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгсөн.

Аймгийн хэмжээнд баригдах 11 барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичиж холбогдох дансанд зураг хяналтын 550000 төгрөгийг төвлөрүүлсэн байна. Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 19 аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгож ажиллаа.

Онцгой байдлын газраас 25 удаагийн ангиллын сургалтаар эрэгтэй 1287, эмэгтэй 783 ажилтан, иргэнийг хамруулсан байна. Аюулт үзэгдэл, ослоос хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин, мал амьтныг хамгаалах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үйл ажиллагаанд албан тушаалтныг сурган дадлагажуулах, хүч хэрэгслийн харилцан ажиллагааг зохион байгуулах, сумдын мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх, аймгийн Засаг даргын Монгол Улсын Шадар Сайдтай 2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-ийг Баянхангай суманд 2022.09.21-23-ны өдрүүдэд Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газар, Улаанзагалмайн анхан шатны хороотой хамтран Баянхангай сумын Онцгой комисс, ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, ерөнхий боловсролын сургууль, иргэд, Алтанбулаг, Аргалант, Баянцогт, Лүн сумдын Онцгой комиссын гишүүдийг хамруулан зохион байгууллаа.

2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 09:00 цагт тус сумын Онцгой комисс, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийн томилгоот 66 алба хаагчдыг сирень дохиогоор дуудаж бэлтгэл бэлэн байдлыг шалган сургуулийн бэлтгэл ажлыг эхлүүллээ.

Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн үеэр сумын хэмжээнд тохиолдож байсан болон тохиолдож болох болзошгүй аюулт үзэгдэл, ослоор цагийн байдал үүсгэн ажиллуулж, гамшгаас хамгаалах дадлага сургуулийг бодит байдалд тулгуурлан зохион байгуулах тал дээр сумын Онцгой комиссын гишүүд болон мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүнтэй уулзалт хийж, тусгай чиг үүргийнхээ дагуу гал түймэр унтраах, нэрвэгдэгсдэд эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хэв журам сахиулах, гамшгийн үед тохиолдож болох хор уршгийг арилгах зэрэг дадлага сургуулийг хийх талаар мөн мэргэжлийн ангиудын бэлтгэл сургуулийн явцтай танилцаж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд тухайн суманд зохион байгуулагдах ангиллын сургалтын удирдамж, хуваарийг батлуулсан.

Удирдамжид тусгагдсан хуваарийн дагуу Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгаас Баянхангай сумын Онцгой комиссын гишүүд, мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн, Аргалант, Алтанбулаг, Баянцогт, Лүн сумын удирдах бүрэлдэхүүнд Гамшгаас хамгаалах тухай хууль, Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах, Монгол улсын хэмжээнд тохиолдсон гамшиг осол, авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний тухай сэдвээр Онцгой байдлын газрын ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Л.Бастөгс, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрэм, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгсэл дайчлан гаргах журам сэдвээр Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч Л.Нямдаваа, Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх аргачлал сэдвээр гамшгийн эрсдэлийн удирдлага үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч П.Өлзийбаяр, Зоонозын халдварт өвчин урьдчилан сэргийлэх арга хэмжээ сэдвээр Эрүүл мэндийн газрын Зоонозын тахвар судлаач Г.Оюунчимэг, Анхны тусламж үзүүлэх заавар сэдвээр Улаанзагалмайн хорооны арга зүйч Б.Нямгал, Хүн, мал амьтны гоц халдварт өвчин, хорио цээрийн дэглэм тогтоох нь сэдвээр Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн Ж.Дорж нар хамтран нийт 16 цагийн танхимын сургалтыг мэргэжлийн ангийн 66 алба хаагч болон 4 сумын 45 удирдах бүрэлдэхүүнийг хамруулан зохион байгууллаа.

Ажлын хэсэг мал эмнэлэг болон хүн эмнэлэгийн үйл ажиллагаатай танилцаж албан хаагчдад хүн, мал амьтны гоц халдварт өвчин гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний дадлага сургууль зохион байгуулах заавар зөвлөгөө болон Баянхангай суманд "Боом өвчин"-ий үед иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, тусгаарлах байрны бэлэн байдлыг хангах, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд объектын гал түймэр гарсан үед нэрвэгдэгсэдийг хэрхэн аврах, анхны тусламж үзүүлэх талаар ярилцаж аврах ажиллагааны үед аврах олсыг хэрхэн зөв ашиглах талаар заавар өгч бэлтгэл ажлыг хангууллаа.

Гамшгаас команд штабын сургуулийн үеэр хил залгаа сумдын удирдах бүрэлдэхүүнд танхимын сургалт зохион байгуулсан бөгөөд танхимын сургалтаар олж авсан мэдлэгээ бататгах, сумдын Засаг дарга нарын зохион байгуулалт болон удирдах бүрэлдэхүүний төлөөллийг гамшигтай тэмцэх ур чадварыг дээшлүүлэх, оролцоог хангах, сургаж бэлтгэх, болзошгүй ослын үед өөртөө болон бусдад тусламж үзүүлэх, гамшгаас хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор "Сорил, дадлага, буухиа тэмцээн"-ийг зохион байгуулж явууллаа.

Хил залгаа Аргалант, Алтанбулаг, Баянцогт, Лүн сумын удирдах бүрэлдэхүүн тус сургалтад хамрагдаж туршлага, мэдээлэл солилцсон юм. Тус арга хэмжээний хүрээнд сумын техник хэрэгсэлийн бэлэн байдал, мэргэжлийн ангийн алба хаагчдын хувийн бэлтгэл бэлэн байдалд үзлэг хийж дутуу болон бэлтгэл бэлэн байдлаа дутуу хангасан алба хаагчдад сануулга өгч ажиллав.

Баянхангай сумын ерөнхий боловсролын 12 жилийн дунд сургуулийн 1-12 дугаар ангийн нийт 250 сурагчдад газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах, эрсдэлийг бууруулах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дадлага, сургалт зохион байгууллаа.

Сумын нутаг дэвсгэрт "Боом өвчин"-ний сэжигтэй тохиолдол илэрсэн үед сумын Онцгой комиссоос авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, иргэдийн тусгаарлан ажиглах байрны бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор Баянхангай сумын Эрүүл мэндийн төвд дуурайлган үзүүлэх дадлага сургалтыг зохион байгуулав.

Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн үеэр сумын хэмжээнд тохиолдож болох мал амьтны гоц халдварт "Шүлхий өвчин"-өөр цагийн байдал өгсөнтэй холбогдуулан тухайн сумын Мал эмнэлэгийн газраас "Шүлхий өвчин"-ний үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, өвчилөлийг хэрхэн хурдан илрүүлэх талаар дадлага сургууль зохион байгууллаа.

Эрэн хайх ажиллагаа: Эрдэнэ сумын Майхан багийн "Хүрэн морьтын зоо" гэдэг газар хүн алга болсон тухай дуудлагыг хүлээн авч 5 алба хаагч, 1 эрэлч нохой, 1 автомашин, Төв аймгийн Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгаас-3 алба хаагч, 1 автомашин, Ар гэрийн 8 хүн. Нийт 16 хүн, 1 эрэлч нохой, 2 автомашинтай ажилласан.

Малын гоц халдварт өвчин: Баян-Өнжүүл сумын Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/115 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон. Төв аймаг Баянцагаан сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/128 тоот захирамжаар тус сумын хязгаарлалтын дэглэмийг цуцалсан. Төв аймаг Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/97 тоот захирамжаар тус сумын хязгаарлалтын дэглэмийг цуцалсан.

Усны осол: Мөнгөнморьт сумын Жаргалант багийн "Тэрэлжийн адаг" гэдэг газарт / аймгийн төвөөс зүүн зүгт 220 км-т, сумын төвөөс зүүн зүгт 40 км-т/ приус 10/ загварын суудлын автомашин "Хэрлэн" голын усанд осолдсон гэсэн дуудлага хүлээн авч тус сумын Гал түймэр унтраах, аврах ангийн 3 алба хаагч, 1 автомашинтай, Цагдаагийн хэсгээс 2 алба хаагч, 1 автомашинтай, Эрүүл мэндийн төвөөс 3 алба хаагч, 1 автомашинтай. Нийт 8 хүн, 3 автомашинтай ажиллаж "Хэрлэн" голын эргээс 2 метрийн зайтай доошоо хөмөрсөн байдалтай байсан. Буцалтгүй нэрвэгдэгчдийг уснаас гаргаж Мөнгөнморьт сумын хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч Л.Ган-Эрдэнэд шилжүүлэн өгсөн.

Гал түймрийн нөхцөл байдал: Объектын гал түймэр болон ой, хээрийн түймрийн дуудлага үгүй, мэдээлэл-2 гарсан.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Газрын даргын баталсан 19/48 дугаар удирдамжийн хүрээнд Архуст, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт сумын Засаг дарга, Газрын даамал нарын 2020-2022 оны эхний хагас жилийн газар олголтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, нийт 105 нэгж талбарыг хүчингүй болгох улсын байцаагчийн 23 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн. Иргэнээс ирүүлсэн 3 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Төв аймгийн Зуунмод, Сэргэлэн, Баянхангай, Заамар, Угтаалцайдам, Аргалант, Батсүмбэр сумдын нутагт улсын болон орон нутгийн чанартай автозамын ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

Шалгалтаар аймгийн Засаг даргын захирамжаар олгогдсон талбайгаас өөр талбайд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан “Анандын зам” ХХК-д зөрчлийн тухай хуулийн дагуу 1,500,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, ус ашиглах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөлгүй, ил уурхайн аюулгүй байдлын дүрэм мөрдөж ажиллаагүй Билэгт зам, Үйлсийн зам, Туулын гүүр далай, Ди Вай Кэй Би ХХК-уудад илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан 15 заалт бүхий 4 хугацаатай албан шаардлагыг хүргүүлж ажиллалаа.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/33 дугаартай удирдамжийн дагуу Алтанбулаг сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

Шалгалтаар Буурлын ар булаг ХХК, Жо интернэшнл ХХК, Пирамид прогресс ХХК, Итгэл түшиг ХХК, Хөх шугам ХХК, Урал дизел ХХК гэх 6 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, Алтансүлжээ системос ХХК, Бөхөг түргэн ХХК, Бетон арматур ХХК, Өндөр буянт холдинг ХХК, Ээмдэ ХХК, Хонгор холдинг ХХК, Тэгш плант ХХК, Шижир хайрга ХХК гэх 8 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй байна.

Шалгалтаар төлөвлөгөөний бус газарт олборлолт явуулж хуульд заасан нийтлэг үүргээ биелүүлээгүй Хөх шугам, Жо интернэшнл ХХК-уудад Зөрчлийн тухай хуулийн дагуу тус тус 1,000,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, Бууралын ар булаг ХХК-д Зөрчлийн тухай хуулийн дагуу 500,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ, Урал дизель ХХК-д албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Төв аймаг дахь Цагдаагийн газраас Төв аймгийн Эрдэнэ сумын 2 дугаар багийн нутаг “Хадан хошуу” гэх газар тусгай зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашигласан гэх м-2720 дугаартай хэрэгт зөрчлийн тухай хуулийн дагуу 200,000 төгрөгийн арга хэмжээ авч ажиллалаа.

Аймгийн Цагдаагийн газраас харъяаллын дагуу шилжүүлэн ирүүлсэн хууль бусаар байгалийн дагалт баялаг ашигласан гэх 3 зөрчил, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээгүй мод тээвэрлэсэн гэх 2 зөрчлийг тус тус шалган зөрчлийн тухай хуулийн дагуу 5 иргэнд 1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 3 иргэнд 3,2 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, торгуулийг 100 %, нөхөн төлбөрийг 82,7 %-тай барагдуулсан. Хууль бусаар бэлтгэсэн 546 кг хуш модны самрыг улсын орлого болгохоор хураан авч аймгийн ЗДТГ-ын орон тооны бус зөвлөлд шилжүүлээд байна.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 19/03 дугаартай “үйлдвэрийн осол, хурц хордлогын актыг хянан баталгаажуулах тухай” удирдамжийн дагуу Хаппи бьюлдинг ХХК-д гарсан 1 үйлвэрийн ослын актыг хянан баталгаажуулж, Илт гоулд, Монвольфрам гарсан 2 үйлдвэрийн ослыг хянаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг эрүүл мэндийн салбарт зохион байгуулах удирдамжийн хүрээнд Төв аймгийн Аргалант, Мөнгөнморьт, Эрдэнэ, Баянхангай, Баянцогт, Угтаалцайдам, Заамар, Цээл, Баянчандмань, Жаргалант, Сүмбэр, Борнуур, Батсүмбэр, Зуунмод, Баяндэлгэр, Архуст, Баянжаргалан, Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Өндөрширээт, Лүн, Сэргэлэн, Алтанбулаг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дэргэдэх 415 дугаар хорих анги, Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн командлалын 016 дугаар нэгтгэл ангиудад улсын үзлэгийн хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан.

Тус үзлэгээр Аргалант, Баянцогт, Цээл, Угтаалцайдам, Сүмбэр, Баянчандмань, Жаргалант, Борнуур, Архуст, Баянжаргалан, Баян, Баян-Өнжүүл, Бүрэн, сумын Эрүүл мэндийн төвүүдэд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 10 заалт бүхий албан шаардлага хүргүүлэв. Мөн Эрдэнэсант сумын МТ-87 дугаар шатахуун түгээх станцаас иргэний гомдол мэдээллээр ирүүлсэн хүсэлтийг холбогдох байгууллагын төлөөлөлтэй уулзаж шийдвэрлэсэн.

Батсүмбэр суманд баригдсан 12 айлын орон сууцны барилга, Эрдэнэсант сум Угалз баг Цагаан өндөр хайрханы оройд баригдсан Мобиком ХХК-ны үүрэн холбооны станцын сайтын барилгыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж 6 үүрэг даалгавар өгч

хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Барилга байгууламжийн ашиглалтын шаардлага хангасан тухай ногоон гэрчилгээг Мобиком ХХК-д хүргүүлж ажилласан.

Төв аймгийн МХГ-ын даргын баталсан 19/51 тоот удирдамжийн дагуу Төв аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 13 цэцэрлэг, 11 ерөнхий боловсролын сургууль, 2 Полтехник коллежид 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгасан. Шалгалтаар ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны үйл ажиллагаанд 1 акт, 3 албан шаардлага, 9 зөвлөмж хүргүүлж, биелэлтийг 100% хангуулж ажилласан.

Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Сүмбэр, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр Зуунмод сумдын 11 ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын 13 байгууллага, Политехник коллежийн 2, сургуулийн дотуур байр 15, хоол үйлдвэрлэл 41 объектыг хамруулан урьдчилан сэргийлэх шалгалт хийлээ. Шалгалтад хамрагдсан 7 ерөнхий боловсролын сургууль өөрийн байранд, 4 сургууль дотуур байранд хоол үйлдвэрлэл явуулж байна.

Судалгаанд 27 сумын соёлын төв, Зуунмод сумын нийтийн номын сан хамрагдсан. Үүнд: монгол бичгээр бичсэн номын фонд- 670 ширхэг, угийн бичиг хөтлөх сурах бичиг-53 ширхэг, мэргэжлийн номын санч 30-аас 26, 86,6%-тай, стандартад нийцсэн орчин нөхцөлд зохих үйлчилгээг үзүүлдэг-66,6%, өөрийн үйл ажиллагааны орлоготой холбоотой хэвлэх цех, дэлгүүр ажиллуулдаг -0,037%, засаг дарга нь номын сангийн сан хөмрөгийг хамгаалах, сэргээн засварлах, баяжуулах, орон нутгийн иргэнийг номын сангийн үйлчилгээнд өргөн хамруулах ажлыг зохион байгуулдаг-11,1%- тай байна.

12,525 га талбайд төмс, хүнсний ногоо 1,930 га-д тариалсан. Одоогийн байдлаар төмсний 7 дээжид 29 үзүүлэлтээр, хүнсний ногооны 37 дээжид 62 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулж 2 дээж эерэг, 42 дээж стандартын шаардлага хангасан үзүүлэлттэй байна. Хяналт шинжилгээ үргэлжлэн хийгдэж байна.

Төв аймгийн Борнуур сумын иргэдээс ирсэн гомдлын дагуу Батсүмбэр сумын Өгөөмөр 1 дүгээр багийн малчин А.Хундармаа /4 дүгээр сараас 6 дугаар сарын дунд үе хүртэл 8 гүүний хээл хаясан/, Нарт 4-р багийн малчин Ө.Тэмүүжин /5 гүүний хээл хаясан/, Мандал 2 дугаар багийн малчин В.Баянтогос /2 гүүний хээл хаясан/ гэх гомдлоор хяналт шалгалт хийж Лэл минерал ХХК-ний төмрийн үйлдвэрийн ундны усны худгаас 3 дээж, төмрийн үйлдвэрийн орчмын суурьшлын бүсийн хөрснөөс 1 дээж, тус үйлдвэрийн ойролцоох Нарт 4 дүгээр багийн ногоочин н.Цэнгэлийн ногооны талбайн хөрснөөс /байцай/ 1 дээж, нийт 5 дээж авч Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний Лавлагаа Лабораторид өгч шинжилгээнд хамруулахад шинжилгээний хариу стандартын шаардлага хангасан.

Хөх чонын хийморь ХХК ирүүлсэн хүсэлтийн дагуу тус компанийн Төв аймгийн Угтаалцайдам сумын Хар чулуут 3-р багийн нутаг Мануултын давааны ар гэдэг газар бэлтгэсэн хадлангийн өвснөөс дээж авч Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн лабораторид шинжилгээнд хамруулан улсын байцаагчийн 1 дүгнэлт гаргасан.

Нордерн дейри ХХК ирүүлсэн хүсэлтийн дагуу Франц улсаас импортлон оруулж ирсэн сүүний чиглэлийн Альпин үүлдрийн 300 толгой ямаанд Батсүмбэр сумын Баянгол 3-р багийн Суурийн 1-1 тоотод байрлуулж хяналт тавьж ажилласан.

Аймгийн ЗДТГ ХХААГ ЖДҮ ийг дэмжигчдийн холбооноос зохион байгуулсан Сүүний баяр-2022 арга хэмжээнд гойд ашиг шимт бух, Өсвөр хээлтэгч, Өсвөр хээлтүүлэгч шалгаруулахад хяналт тавьж ажиллав.

Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 38 дээжинд 122 үзүүлэлт (Гурил гурилан бүтээгдэхүүнд 3 сорьцонд 11, Хоолны 3 сорьцонд 16, мах махан бүтээгдэхүүн 3 сорьцонд 9, сав баглаа боодол (уут) 2 сорьцонд 2, гүний усны 20 сорьцонд 60, төвлөрсөн системийн ус 4 сорьцонд 12, Хөрс 3 сорьцонд 12), үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан. Үүнээс: Эерэг Стандартын шаардлага хангаагүй 6 сорьц 6 үзүүлэлт байна.

Эрүүл ахуй химийн лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 21 сорьцонд 89 үзүүлэлтээр (Төмс хүнсний ногооны 2 дээжинд 4 үзүүлэлтээр, Гүнийн ус 6 дээжинд 72 үзүүлэлтээр, Хоолны 13 дээжинд 13 үзүүлэлт) эрүүл ахуй химийн шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан байна. Үүнээс: эерэг стандартын шаардлага хангаагүй дээж илрээгүй болно.

Нэгж лабораториудад нийт 59 сорьцонд 211 үзүүлэлтээр шинжилгээг хийж үр дүнг цаг хугацаанд нь хянаж, баталгаажуулан гаргасан.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд хууль зүйн салбарын хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг тусган аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ.

Хууль зүй дотоод хэргийн яамнаас Хууль зүй дотоод хэргийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны хамтран ажиллах гэрээний хагас жилийн хэрэгжилтийг 74.9 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнүүлээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр аймгийн Засаг даргын харьяа агентлагуудын удирдах албан тушаалтан, албан хаагчдад чадавхжуулах сургалтыг зохион байгуулж 37 байгууллагын 42 албан хаагчийг хамрууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу сум, байгууллагад зөвлөн туслах ажлыг зохион байгуулж аймгийн Засаг даргын харьяа байгууллагууд болон Баян-өнжүүл, Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архив, албан хэрэг хөтлөлт, захирамжлалын баримт бичгийн эрх зүйн үндэслэл, хүний эрх, хэрэглэгчийн эрхийг хангах чиглэлээр мэргэжил, арга зүйгээр хангаж, архив албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр сумын төсөвт байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад хугацаатай үүрэг чиглэл хүргүүлээ.

Аймгийн 100 жилийн ойг угтаж сум, байгууллагуудын түүхэн ойтой холбоотой ном, дурсгалын зүйлсийг цуглуулан аймгийн Төрийн архивт үзмэр, номын сан бий болгох ажлыг эхлүүлээ.

ТӨРИЙН АРХИВЫН ТАЛААР:

Төрийн архивын эх баримтаас байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 100 иргэний хүсэлтийг хүлээн авч 498 хуулбар хувь олгож, 53 лавлагаа, 122 хөмрөгийн 415 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан лавлагаа үйлчилгээ үзүүлж орон нутгийн төсөвт 344.0 төгрөгийг орууллаа.

3 хөмрөгийн 20 хадгаламжийн нэгжийн 1122 хуудас баримтын 5104 хүний нэр, 284 заалтын тоо, 284 тушаалын тоог мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, 3 хөмрөгийн 8 хадгаламжийн нэгжийн 507 хуудас баримт скайнердаж 2 хөмрөгийн 8 хадгаламжийн нэгжийн 284 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 284 заалтын 469 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбон цахим бааз үүсгэлээ.

Баримтын нөхөн бүрдүүлэлтээр “Мандал ватт “ХХК Баянчандмань сум иргэн А.Мутайн ахуйн зориулалтай гадна цахилгаан хангамж 2 хадгаламжийн “Мандал Ватт” ХХК Батсүмбэр сум иргэн Ч.Отгонбаатар ахуйн зориулалтай гадна цахилгаан хангамж 2, Нотариатч Д.Намбар 2021 оны 33, “Ардчилсан холбоо”2012-2021 оны 21, аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг 2012-2021 оны 21, аймгийн бөхийн холбоо” 2009-2021 оны 21 нийт 100 хадгаламжийн нэгжийг хүлээн авч баримтын тоо бүртгэл хөтлөн хадгаламжийн санд бүртгэлээ.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 64.081 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138.315 газар өмчлөх эрхийн 52.497 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 1292 /9 сард хүлээн авсан мэдүүлэг /1292/

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 257.1 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 161.4 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 6.7 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2828 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 21 нэмэлт өөрчлөлт, шинээр 18 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 0, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 3, эцсийн өмчлөгч 7 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 8 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 0 лавлагаа өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого 16.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 577 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20,7 хувиар өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 51.0 хувьтай, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7,3 хувиар өссөн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-13, албадан

саатуулагдсан-16, шүүхээр баривчлагдсан-34 нийт 63 хүнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед эрүүл мэндийн үзлэг хийж, хүлээн авч ажиллалаа.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Олон нийтийг хамарсан 7, чиглэлийн 1, зочны 5 хамгаалалт, олон нийтийг хамарсан 8 арга хэмжээнд нийтийн хэв журам сахиулж давхардсан тоогоор 52 тээврийн хэрэгсэлтэй, 221 алба хаагч ажиллаж олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр

2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 86 жолоочийг илрүүлж, 83 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 23 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэж ажиллалаа. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 6000 жолоочийг 211,3 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 86 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулж зөрчлийг арилгууллаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Криминалистикийн шинжилгээ-133, магадлан шинжилгээ-196, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-443, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-117, гарын хээний санг дардсаар баяжуулсан-599 мөрөөр баяжуулсан-80, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-126, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-196, гистологийн шинжилгээ-196 тус тус хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
09-р сар	217	528	9	736	408	328	55.4
	4587209.8	2724880.8	178844.7	7133245.9	2408989.8	4724256.1	

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны явц, удирдлага зохион байгуулалт, салбарын хүрээнд батлагдсан бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар зохион байгуулж байгаа ажлын үр дүн, бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хяналт хийж, албан хаагчдыг арга зүйн зөвлөмжөөр хангах зорилго бүхий аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 3 ажлын хэсэг 28 хэлтэс, агентлаг, харьяа байгууллагад шалган туслан ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын чиглэлээр:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Засаг даргын тусгай сан, ОНХС, Төв Чандмань ДЭХГ-ын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын Бүжинхэн, Дэгдээхий, Ирээдүй, Унагалдайн андууд, Хүмүүн цэцэрлэгүүд, 4-р сургууль, 5-р сургууль, Хүмүүн цогцолбор цэцэрлэг, Бумбардай цэцэрлэг, Зуунмод сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв, Хот тохижуулах газар, Баруун Зуунмод ББН өрхийн ЭМТ, ГБХЗХГ, аймгийн музей, Насан туршийн боловсролын төв, Аймгийн ИТХ, Заамар сумын МСҮТ, Архуст, Баян, Баянжаргалан, Баянцогт, Аргалант, Лүн, Баянхангай, Угтаалцайдам, Цээл, Заамар сумдын төсөвт байгууллагуудын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв.

Баянцагаан сумын ЭМТ, Мөнгөнморьт сумын ЗДТГ, Татварын хэлтэс, ОНХ-ийн сан, ЭЭС, Сумдын сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, өргөдлөөр аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тус тус хийж 5,531,481.5 төгрөгийн зөрчил илрүүлж 345,070.1 төгрөгийн зөрчилд улсын ахлах

байцаагчийн акт, 2,002,421.7 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 3,186,989.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллаа.

Өмнөх оны актын үлдэгдэл 171,193.5 мянган төгрөгөөс 68,861.4 мянган төгрөг, 2022 онд тогтоосон актаас 131,691.1 мянган төгрөг тус тус барагдсан байна.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө эхний 08-р сарын байдлаар орон нутаг 16117.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 16188.8 сая төгрөг төвлөрүүлж 100.4 хувьтай, 71.1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 3686.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 5202.2 сая төгрөг төвлөрүүлж 141.1 хувьтай, 1515.7 сая төгрөгөөр давж биелсэн.

3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 2229,2 сая төгрөгөөр биелж, 109,8 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Батсүмбэр, Баяндэлгэр, Заамар, Мөнгөнморьт, Эрдэнэ, Зуунмод зэрэг 6 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Архуст, Баян, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Дэлгэрхаан, Лүн, Сэргэлэн, Сүмбэр, Угтаал, Эрдэнэсант зэрэг 15 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баянхангай, Баянцагаан, Бүрэн, Жаргалант, Өндөрширээт, Цээл зэрэг 6 сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Сумдад 2022 оны 08 сарын байдлаар нийт 41985,5 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон. Орон нутгаас Боловсрол шинжлэх ухааны байгууллагад 7647,5 сая төгрөгийн санхүүжилт

-Эрүүл мэндийн байгууллагад 457,0 сая төгрөгийн санхүүжилт

-Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 18140,6 сая төгрөгийн санхүүжилт

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 15740,4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

2022 оны 08-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 176,6 сая төгрөгийн авлага, 337,5 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 204,5 сая төгрөг буюу 60,6 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 6,5 сая төгрөг буюу 1,95 хувь нь цалингийн өглөг, 0,7 сая төгрөг буюу 0,22 хувь нь НДШимтгэлийн өр, 28,0 сая төгрөг буюу 8,3 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 97,8 сая төгрөг буюу 29,0 хувийг бусад өр эзэлж байна

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

Хөрөнгө оруулалт: Аймгийн хэмжээнд 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 59,489.7 сая төгрөгийн 97 төсөл, арга хэмжээг тусган баталж үүнээс тендер шалгаруулалт зохион байгуулахаар 59,334.7 сая төгрөгийн 86 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. 2022.04.29-ны өдөр Монгол Улсын Их Хурал 2022 оны улсын төсөвт тодотголоор 621.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг зогсоосон.

2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах зорилтын хүрээнд 9 дүгээр сарын байдлаарх худалдан авах ажиллагааны явцын мэдээлэл:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 39,759.7 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээнээс 39,559.7 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнд 38,151.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Соёлын яамнаас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 20.0 сая төгрөгийн, Сангийн сайдын шийдвэрээр Жаргалант сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажлын тендерүүдийг зарласан.

2. Аймгийн шилжих үлдэгдлээс нийт 6,424.6 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээнээс 2,854.6 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулж, 170.0 сая төгрөгийн 2 ажлын тендерийг үнэлгээний хороо үнэлгээ хийж, 100.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээнд тендер зарлагдсан. Мөн 3 тэрбум төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний тендерийг дахин зарлах эсэх талаар захиалагч байгууллагад хандаж хариу хүлээж байна. Сумдад эрх шилжүүлсэн 300.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний тендерийг эрх хүлээн авсан сумд цахим системээр дахин зарлахаар ажиллаж байна.

3. Аймгийн Замын сангийн хөрөнгөөр нийт 2,742.6 сая, төгрөгийн 3 ажлаас 2,222.6 сая төгрөгийн төсөвтэй 2022 онд 190.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх 1 төсөл, арга хэмжээ, Сэргэлэн, Лүн, Зуунмод сумдын авто замын зураг төсөл боловсруулах 120.0 сая төгрөгийн 1 ажлын тендер зарлаж 289.2 сая төгрөгийн гэрээг байгуулсан. Мөн 400.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж захиалагч үнэлгээний хорооны дүгнэлтийг хянан үзэж байна.

4. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5,504.3 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээнээс 4,639.4 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах эрхийг олгосноос захиалагч 26 ажилд гэрээ байгуулсан. 150.0 сая төгрөгийн 2 ажилд гэрээ байгуулах шатанд ажлын 6 хоног хүлээж байна. Сумын түвшинд үнэлгээний хороо үнэлгээ хийж буй 160.0 сая, төгрөгийн 2 ажил байна.

5. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,206.9 сая, төгрөгийн 6 төсөл, арга хэмжээнд 100 хувь тендер зарлаж, 6 ажилд 1.161.1 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна.

6. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар нийт 608.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас гэрээ байгуулагдсан 244.0 сая төгрөгийн 3 ажил, хэлэлцээрийн үр дүнгээр гэрээ байгуулагдах 300.0 сая төгрөгийн 1 ажил нь ажлын 6 хоног хүлээж, гэрээ байгуулах шатанд байна. Захиалагчийн шийдвэрээр 64.0 сая төгрөгийн 1 ажилд гэрээ байгуулагдсан.

7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын эрүүл мэндийн төвийн 2022 онд шаардагдах: 1 төсөл, арга хэмжээ-дотроо нийт 32 багцтай 1,600.0 сая, төгрөгийн төсөвт өртөгтэй бараа худалдан авах тендерийг зарлаж 32 багцад шалгаруулалт хийж, гэрээ байгуулагдсан.

8. Гадаадын хөрөнгө оруулалтаар Япон улсын санхүүжилтаар Хүмүүн цогцолбор сургуулийн барилгын дотор засварын ажлын тендерийг 2 дахь удаагаа зарлаж, нээлтийг 2022.07.18-нд зохион байгуулсан. 6 оролцогчтой үнэлгээний хороо үнэлгээ хийж байна.

Барилга захиалагч, хяналтын чиглэлээр: Аймгийн ИТХ-ын 2022.09.08-ны 11 дүгээр хуралдаанд Мөнгөнморьт сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус хэлэлцүүлэн батлуулсан.

2022 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 46 төсөл арга хэмжээ төсөвт өртөг 91,307.1 сая төгрөг, 2022 онд 26,285.7 сая төгрөг санхүүжих дүнтэй ажилд захиалагчийн чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байна. 2022 онд улсын хөрөнгө оруулалтаар 20 барилга байгууламж 27.0 тэрбум төгрөгийн ажлууд хийгдэж байна.

Хот байгуулалтын кадастрын чиглэлээр: Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрмийн дагуу Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2022 онд 62 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан ба энэ сард 5 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.

Энэ сард зураг төсөл боловсруулах 3 зургийн даалгавар боловсруулан батлаж, нийт 40 боловсруулан баталсан. Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах, ерөнхий төлөвлөгөө батлах ажлын хүрээнд энэ сард 23 зураг төсөл батлаж, нийт 128 зураг төсөл зөвшөөрөлцөөд байна. Барилга, инженерийн байгууламжийн зураглалыг шалгаж, хот байгуулалтын мэдээллийн санд 9 гүйцэтгэлийн зураг хүлээн авч акт олгосон.

Засгийн газрын 2021 оны 212, 213 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах” дүрмийн хүрээнд Барилга эхлүүлэх зөвшөөрөл энэ сард 16 барилга байгууламжид олгож, нийт 91 барилга байгууламжид олголоо. Барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд энэ сард 11 барилга байгууламж ашиглалтад орж, нийт 45 барилга байгууламжийг ашиглалтад орлоо.

Газрын кадастрын чиглэлээр: 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа Аргалант сумын 12 нэгж талбар, Алтанбулаг сумын 4 байршилд нэгж талбар, Баянцогт сумын 1 нэгж талбар, Баянхангай сумын 1 нэгж талбар, Цээл сумын 1 нэгж талбар, Мөнгөнморьт сумын 1 нэгж талбар нийт 20 нэгж талбарын газрын дуудлага худалдааны зарыг www.mle.mn сайтад баталгаажуулсан. Мөнгөнморьт сумын 5 нэгж талбарын төсөл сонгон шалгаруулалтыг баталгаажуулсан. Газрын кадастрын системд зөрүүтэй үүссэн 35 газрын төлбөрийн нэхэмжлэлийг засварлаж шинэчилсэн.

Улсын хэмжээнд хийж гүйцэтгэсэн “Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн Газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах ажил”-ын хүрээнд зөрчилтэй гэж тогтоогдсон нэгж талбарын зөрчлийг хэрхэн арилгах зөвлөмжийг Газар зохион байгуулалт,

геодези, зураг зүйн газраас 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1765 тоот албан бичгээр ирүүлсэн. Тус зөвлөмжийн дагуу сумдад зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилгах чиглэлийг 09 дүгээр сарын 28-ны өдрийн 07/842 тоот албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд газрын кадастрын мэдээллийн санд 9-р сард нийт 112 өргөдөл ирснээс 61 өргөдлийг шийдвэрлэж шинээр 51 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.

Газрын төлбөр: Газрын төлбөр, дутуу төлөлт, дуудлага худалдааны орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлын зохион байгуулж, 2022.09.28 өдрийн байдлаар газрын төлбөрийн орлогоос 1781,0 сая төгрөг аймаг болон сумын дансанд төвлөрүүллээ.

Газар зохион байгуулалт: Зуунмод суманд газар эзэмшиж буй иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтын байдалд хяналт дүгнэлт хийх ажлын хэсгийг байгуулж 53 иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтын байдалд дүгнэлт хийж, газар эзэмших эрхийг цуцлах, газар ашиглалтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэх тухай ажлын хэсгийн дүгнэлт, тайланг гарган, мэдэгдлийг хүргүүлэхээр ажиллаж байна.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 121 дүгээр тогтоолын батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, аймгийн хэмжээнд 2022 оны 3-р улирлын байдлаар өссөн дүнгээр 73452 иргэнд 13449.64 га газар өмчлүүлж газар өмчлөлийн явц 78 хувьтай байна.

2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршил зориулалтын саналыг боловсруулж урьдчилсан байдлаар өмчлүүлэх газрын төлөвлөлтийн саналыг 26 сумаас хүлээн авч газар зохион байгуулалтын цахим системд боловсруулан танилцуулж байна.

Улсын чанартай зам дагуу шинээр өмчлүүлэх 858 иргэнд 67.15 га, Эзэмшиж буй газрыг өмчлүүлэх 205 иргэнд 22.22 га, Сумын төв болон суурин газарт шинээр өмчлүүлэх 3065 иргэнд 529.31 га, Нөхөн олговортойгоор солих газар 2 иргэнд 1 га, Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр нь өмчлүүлэх 1 иргэнд 0.18 га, нийт 4131 иргэнд 619.86 га газрыг өмчлүүлэх төлөвлөснийг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулаад байна.

Өмчийн хүрээнд: Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлыг эрчимжүүлэх, сумдын тооллогын ажлын гүйцэтгэлийн явцтай танилцахаар Орон нутгийн өмчийн газрын даргын батласан удирамжийн дагуу 2022.09.12-19 ны өдрүүдэд өмчийн мэргэжилтнүүд 10 суманд 2 баг болон тооллогын ажлын нэгтгэлтэй танилцан мэргэжил арга зүйгээр ханган тайланг эцэслэн дуусгаж, сумын ажлын хэсгийн тоолсон үндсэн хөрөнгийг нэг бүрчлэн нүд үзэн тоолж нягтлан баталгаажуулан илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хугацаатай үүрэг чиглэлийг өгч ажилласан.

Эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын нэгдсэн программд 2022 оны 09 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт 228 байгууллага хөрөнгийн бүртгэл ирүүлэхээс 222 байгууллагын тайлангаа баталгаажуулж, 2 байгууллагын тайлан буцаагдаж, тайлангаа хугацаандаа илгээгүй 4 байгууллагын удирдлагуудад албан шаардлага хүргүүлсэн.

Түрээсийн орон сууцны хүрээнд: Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг хэрэгжүүлэн 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13, 2021 онд 1 өрх нийт 26 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулж, 2022 оны 08 сарын байдлаар 26 айлын түрээсийн төлбөр 31.4 сая төгрөгийг түрээсийн орон сууцны санд төвлөрүүллээ.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 800.0 сая төгрөгийг шийдвэрлэн, тендерт Төв цогт өлзий ХХК шалгарч, 40 айлын орон сууц барилгын ажлын эхэлсэн Ажлын явц 50 хувьтай байна.

Авто замын салбарын хүрээнд: Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн тээвэрлэлтийг дэмжих Нутгийн зам төслийн хүрээнд Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122,4 км хатуу хучилттай автозамын төслийн 4 багц тендерт гүйцэтгэгчээр "Туулын гүүр далай" ХХК, "Ди Вай Кей Би" ХХК, "Туулын гүүр далай" ХХК, Билэгт зам ХХК тус тус шалгарч, зам барилгын ажил хийгдэж байна.

Зуунмод-Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлыг холбосон авто замын барилгын ажлыг 8161.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. Зам барилгын ажлын гүйцэтгэгчээр Анандын зам компани шалгаран гэрээ байгуулан ажлын гүйцэтгэл 70 хувьтай хэрэгжиж байна.

Мал аж ахуйн хүрээнд: Аймгийн Засаг Даргын 2022 оны А/522 тоот захирамжийн дагуу “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нутгийн Баянцагаан өсвөр хуцыг сумдад хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулж, Алтанбулаг, Аргалант, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Заамар, Зуунмод, Мөнгөнморьт, Өндөрширээт, Эрдэнэ, Эрдэнэсант, Угтаалцайдам, Цээл зэрэг 17 суманд 360 толгой хуц хүлээлгэн өгч, малыг үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүллээ.

Аймгийн хэмжээнд 18 сумын 91481 толгой үхэр сүргийг ээмэгжүүлэн, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд Зуунмод, Сэргэлэн, Цээл сумд 9481 үхэр сүргийг ээмэгжүүлэх ажлыг гүйцэтгэсэн, намрын технологит хугацаа үргэлжилж байна.

Монгол Улсын гавьяат нэгдэлчин, улсын аварга саальчин Пүрэвжавын Чанцалдуламын мал маллагааны арга барил, “Малчны хөдөлмөр-Сүүний үнэртэй” сэдэвт, улс, аймаг, сумын аварга, мянгат малчдын зөвлөгөөнийг Эрдэнэ суманд зохион байгуулж, Мал аж ахуйн салбарын бодлого хөтөлбөр, мал үржүүлэг, малын тэжээл, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломж зэргээр мэдээлэл өгч, “Гар тэжээл, бэлтгэх аргачлал, зөвлөмж”, “Цахимаар урамшуулал” зэрэг гарын авлага тараах материалаар нийт 200 гаруй иргэнд үйлчилгээ үзүүллээ.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хадлан тэжээлийн бэлтгэл 9-р сарын байдлаар 14560.3 тн хадлан, 28.8 тн гар тэжээл, 1896.0 тн ногоон тэжээл, 263.1 тн үйлдвэрийн тэжээл тус тус бэлтгэсэн. Аймгийн аюулгүйн нөөц бүрдүүлэх 150 тн өвсний тендерийг зарлаж, тэжээл 100% бүрдүүлсэн. Сумдын аюулгүйн нөөц бүрдүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд 9-р сарын байдлаар өвс 27.6 хувьтай, тэжээл 11.0 хувьтай байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээнд: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1585.0 мян.тол мал хамруулахаар төлөвлөн Биокомбинат ТӨХХК-тэй гэрээ байгуулан эм биобэлдмэлийн татан авалт 100.0%, дархлаажуулалт 101.7 хувьтай хэрэгжиж дууссан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/468 тоот захирамжаар 5 суманд бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 724900 толгой мал хамруулахаас 718863 толгой мал хамруулж 99.1 хувьтай хэрэгжсэн.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 1134.2 мян.тол мал хамруулахаас 1024.9 мян.тол мал хамруулж 90.4 хувьтай, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтад 420400 толгой мал, амьтан хамруулахаас 184849 толгой мал хамруулж 43.97 хувьтай явагдаж байна.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх 4 нэр төрлийн арга хэмжээнд 7.9 сая толгой мал хамруулахаас 6.0 сая толгой мал хамруулж 76.0 хувьтай, 1350 мян.м2 талбайд халдваргүйтгэл хийхээс 1180.4 мян.м2 талбай буюу 87.4 хувьтай явагдаж байна.

Баянцагаан, Алтанбулаг, Баян-Өнжүүл суманд бог малын мялзан өвчин оношлогдон 4 голомтод 6 өрхийн 237 мал өвчилж үүнээс 61 хорогдож 176 малын шинж тэмдэг арилсан. Баянцагаан сумын 1 голомт, Алтанбулаг сумын 1 голомтын хязгаарлалтын дэглэм буурсан. Баянцагаан сумын 1 голомт, Баян өнжүүл сумын 1 голомт хязгаарлалтын дэглэмтэй байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр аймгийн Засаг даргын 2022 оны А/476 тоот захирамжаар 2 ажлын хэсэг байгуулан бог малын мялзан өвчин оношлогдсон голомт бүхий сумдад, бог малын мялзан өвчний дархлаажуулалт хийсэн 5 суманд дархлаажуулалтын явцын хяналт шалгалт хийгдэж, үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/468 тоот захирамжаар 5 суманд бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг эхлүүлэн өнөөдрийн байдлаар 357.6 мян.тол мал хамруулж 51.61 хувьтай явагдаж байна.

Тайлант хугацаанд 1863 гарал үүслийн гэрчилгээ баталгаажуулсанаас адуу 926, үхэр 558, хонь 7561, ямаа 2789, гахай 2 нийт 11836 толгой амьд мал, 637963 кг мах, 10490 кг дайвар бүтээгдэхүүн, 1044305 литр айраг сүү, 10580 кг цагаан идээ, 17480 кг ноосонд гарал үүслийн гэрчилгээ олгож 9 дуудлагын дагуу 30 малд үйлчилгээ үзүүллээ.

Газар тариалангийн хүрээнд: Ургац хураалт 09-р сарын 27-ны өдрийн байдлаар Үр тариа 10729 га-аас 3039.4 тн, төмс 9795 га-аас 114197 тн, хүнсний ногоо 824 га-аас 7322 тн, таримал тэжээл 2252 га-аас 6884 тн, тосны ургамал 2559 га-аас 694 тн ургац тус хураагаад байна. Ургац хураалт 46 хувьтай явагдаж байна.

Ургац хураалтад гаднаас 1113 ажиллах хүч ажиллаж, 6 их дээд сургуулийн 1250 оюутан, 830 цэрэг нийт 3193 хүн ажиллаж байна.

Ургац хураалтын ажлыг оновчтой зохион байгуулах, технологийн зөвлөмж, үүрэг чиглэл өгөх, 9, 10 сарын цаг агаарын урьдчилсан мэдээ, хүйтний улирлын төлөв байдлын талаар

мэдээлэл хүргэх зорилгоор аймгийн тариаланчдын зөвөлгөөнийг тариалан бүхий сумдаа 5 бүс болгон Зүүн бүсийн зөвөлгөөнийг Архуст суманд, Баруун бүсийн зөвөлгөөнийг Цээл суманд тус тус зохион байгуулан нийт 75 тариаланч хамрагдлаа.

Тариалангийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилтын хүрээнд 2023 оны тариалалтад шаардагдах нутагшсан, баталгаажсан үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор үр тарианы талбайд үрийн сортын хянан баталгаа хийх ажлыг МХГазар, ОБГазартай хамтран зохион байгуулж 6 сумын 10 аж ахуйн нэгжийн 1770 га талбайд сортын хянан баталгаа хийсэн. Хянан баталгаанд Ирень, Новосибирск, Алтайская 352, Бурядская остистая сортууд хамрагдсан.

Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын санаачлагаар намрын ургац хураалтын үеэр хүн хүчний дутмаг байгаа сумдад хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх зорилгоор аймаг хөгжүүлэх сангийн зээлээр Жаргалант суманд хурааж, ангилж шуудайлдаг Польш улсад үйлдвэрлэсэн төмсний 1 мөрний комбайн, Сүмбэр, Борнуур сумдад лууванг хурааж, ангилж, савалдаг Япон улсад үйлдвэрлэсэн луувангийн комбайныг тус тус олголоо.

Аймгийн шууд харилцаат Япон улсын Тоттори мужийн Газар тариалангийн Хүнсний ногооны судалгааны албанаас томилогдож ирсэн япон мэргэжилтэн Борнуур, Зуунмод, Батсүмбэр, Баянчандмань сумдад 5 өдөр ажиллаж, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч 60 гаруй ногоочин, 3 аж ахуйн нэгжид “Броколли, гүзээлзгэнэ, тарvas тариалах технологи” сэдэвт танхимын сургалт хийж, талбайн зөвлөгөөг өгсөн.

ХХААХҮЯ, Тогтвортой ХАА төсөл “Газар тариалангийн салбарын боловсрол, экстейншн, боловсон хүчин” сэдэвт сургалтад газар тариалангийн 1 мэргэжилтэн хамрагдсан.

Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Намрын ногоон өдрүүдэд-Үндэсний үйлдвэрлэл-2022” үзэсгэлэн арга хэмжээнд 9 иргэн, аж ахуйн нэгж, хоршоо 68 нэр төрлийн бүтээгдэхүүн оролцож нийт 36,2 сая төгрөгийн борлуулалтаар дэмжигдэж, Алтанбулаг сумын Эко ногоо брэнд хоршоо “Газар тариалангийн шилдэг хоршоо”, Эрдэнэ сумын “Мон пеллетс ХХК-ний үйлдвэрлэсэн ноосон бордоо “Экспортын шилдэг бүтээгдэхүүн”-ээр тус тус шалгарлаа.

“Шинэ мах-Шинэ сүү- Шинэ ногоо” борлуулалтын цэг байгуулах чиглээр шинээр байгуулагдсан “Улиастай нэгдсэн зах” худалдааны төвтэй хамтран ажиллаж, нээлтийн арга хэмжээнд Алтанбулаг, Архуст, Баяндэлгэр, Баянжаргалан, Эрдэнэ сумын 11 аж ахуйн нэгж, иргэн, хоршооны төлөөлөл 25 нэр төрлийн бүтээгдэхүүн оролцож 2,5 сая төгрөг борлуулалтаар дэмжигдэн, цаашид мах, хүнсний ногооны худалдааны цэг байгуулах нөхцөл бүрдлээ.

“Уул уурхайн худалдан авалтад орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг холбох арга зүй” сургалтыг Мерит төсөлтэй хамтран зохион байгуулж, Борнуур, Баянчандмань, Баянцагаан, Баянжаргалан, Жаргалант, Заамар сумын жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хамрууллаа.

ЖДҮХСангийн 2 дугаар шатны сонгон шалгаруулалтад 9 сумын 13 аж ахуйн нэгжийн 1.7 тэрбум төгрөгийн төсөл шалгарч, газар дээр нь үнэлгээ хийх ажил явагдаж байна.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт ажлын хүрээнд: Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын чиглэлээр: Худалдаа, үйлчилгээ бүтээгдэхүүний тохирлын үнэлгээнд, Баян, Баянчандмань, Бүрэн, Баянцогт, Сэргэлэн, Зуунмод, Эрдэнэ, сумын 25 худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэгчдийг хамруулж, бүтээгдэхүүн -1, худалдаа -13, нийтийн хоол-2, амралтын газар -5 нийт 20 худалдаа үйлчилгээний цэг, 1 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ 1-2 жилийн хугацаатай олголоо.

Хэмжил зүйн лаборатори: Хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын чиглэлээр: Баян, Баяндэлгэр, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Зуунмод, Эрдэнэ сумын нүүрс тээвэрлэлт, худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны газар худалдаа, үйлчилгээний хэмжлийн 2 төрлөөр нийт 1991ш хэмжих хэрэгсэл шалган баталгаажууллаа.

Орчны бохирдлын талаар: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022.09.08-ны өдрийн 11-р хуралдааны 09 дүгээр тогтоолоор “Энгийн болон аюултай хог хаягдлын өндөр технологийн төвлөрсөн эко байгууламж” байгуулах зорилгоор Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт 20га газрын улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжин, аймгийн Засаг даргын 2022 оны 09 сарын 20-ны өдрийн 01/1511 дугаар албан тоотоор Байгаль орчин аялал жуулчлалын яам болон Барилга хот байгуулалтын яаманд уламжилсан.

2022 оны 08-р сарын 25-наас 09-р сарын 15-ны хооронд аймгийн хэмжээнд “ТАМХИНЫ ИШ”-ийг хүрээлэн буй орчноос цэвэрлэх, цаашид тамхины ишийг ил задгай хаяхгүй байх дадал зуршлыг төлөвшүүлэх уралдааныг зохион байгууллаа. Тамхины иш түүх уралдаанд 1-р

байр Эрдэнэсант сум /163 ширхэг сав/, 2-р байр Батсүмбэр сум /90 ширхэг сав/, 3-р байр Угтаалцайдам сум /54 ширхэг сав/, Уут урлах уралдаанд 1-р байр Эрдэнэсант сум /148 ширхэг/, 2-р байр Угтаалцайдам сум /35 ширхэг/ тус тус шалгарч, иргэдэд тамхины ишийг ил задгай хаяхгүй байх дадал зуршлыг төлөвшүүлэхэд чиглэж ажиллалаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар хуралдааны 3-р тогтоолоор баталсан байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд гэр хорооллын айл өрхүүдэд ангилан ялгах сав байршуулахаар тусгасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, ЭБЭТ ХХК энэхүү ажлыг гүйцэтгэж, Мөнгөнморт, Алтанбулаг сумдын 130 өрхийн хашаанд суурилууллаа.

Усыг хамгаалах, зүй зохистой ашиглах ажлын хүрээнд: Усны сан бүхий газрыг бохирдож, хомстохоос хамгаалах арга хэмжээний тухай” 09 тоот албан даалгаврыг 2022.09.01-09.12 өдрүүдэд Төв аймагт зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Албан даалгаврын хүрээнд 9 сумын 25 усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс орчмын 51.7 га газрын 33.1 тн хог хаягдал, 500 гаруй үхсэн малын сэг зэмийг 3 ковш, 8 портер, 5 маяги, 18 морь ашиглан цэвэрлэсэн. Тухайн ажлыг 38 аж ахуйн нэгж, байгууллага, иргэд зэрэг 319 хүний оролцоотойгоор зохион байгууллаа. Мөн усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд хориглох үйл ажиллагааны мэдээлэл бүхий уриалгыг 113 иргэн, аж ахуйн нэгжид хүргэн ажилласан.

Биологийн төрөл зүйлийн ажлын хүрээнд: Төв аймгийн хэмжээнд ан амьтны хомсдлоос сэргийлж, агнуурын нөөцийг хамгаалах зорилгоор 14 байршлын 190 мянган га талбайг аймгийн тусгай хэрэгцээнд авах саналыг Баяндэлгэр, Борнуур, Жаргалант, Угтаалцайдам, Баянжаргалан, Баянцогт, Сэргэлэн, Цээл сумдын Засаг дарга, ИТХ-д хүргүүлж дэмжүүлээд байна.

Аялал жуулчлалын чиглэлээр: Дэлхийн аялал жуулчлалын өдрийг угтаж “Аялал жуулчлалын нөхцөл байдлыг эргэцүүлэн бодож төлөвлөх нь” уриан доор аймгийн 27 сумын ЕБС-ийн сурагчдыг, сумын түүх соёлын дурсгалт газруудаар танин мэдэхүйн аялал зохион байгуулж байна. Баян- Өнжүүл, Лүн, Баянцогт, Сүмбэр, Баянхангай, Жаргалант сумдын 200 хүүхэд хамрагдаад байна.

Цаг агаарын байдлыг урьдчилан мэдээлэх: Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм мэдээг тус тус гаргаж, И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, төв талбай болон байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна. 09 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд Төв аймгийн нутгаарбороо, уулаараа нойтон цас орж, салхи шуургатай сэрүүхэн байхыг онцгойлон анхааруулах мэдээг 12-48 цагийн өмнө 2 удаа, 09 дүгээр сарын 04, 17-нд хөрсөн дээр хасах 0-5 градус хүрч цочир хүйтрэх сэрэмжлүүлэх мэдээг 12-48 цагийн өмнө 2 удаа, 09 дүгээр сарын 19, 21-нд Төв аймгийн нутгаар хөрсөн дээр -5 градусыг давж цочир хүйтрэх урьдчилан сэргийлэх мэдээг 12-48 цагийн өмнө 2 удаа гаргаж www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан үйлчиллээ.

Байгаль орчны шинжилгээний лаборатори: Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 09 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар нийт 34 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн дундаж агууламж 0.005 мг/м³ азотын давхар ислийн дундаж агууламж 0.009 мг/м³ үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хийн дундаж агууламж 0.001 мг/м³-ээр буурсан, азотын давхар ислийн дундаж агууламж 0.003мг/м³-ээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Ус судлалын салбар: Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2022 оны 09 дугаар сарын 21-ний байдлаар усны түвшин: Хэрлэн гол Хэрлэн-Хонгон 156 см, Хэрлэн-Мөнгөнморьт 150 см, Туул гол Туул-Алтанбулаг харуулд 596 см, Туул-Лүн харуулд 165 см, Туул-Заамар харуулд-206 см, Сөгнөгөр-Сөгнөгөр 200 см, Шивэрт-Борнуур 139 см тус тус байсан ба өмнөх оныхтой харьцуулахад усны түвшин Хэрлэн голын дагуух Хэрлэн-Хонгон, Хэрлэн-Мөнгөнморьт харуулууд 12 см бага, Туул голын дагуух Туул- Алтанбулаг, Туул-Лүн харуул, Туул-Заамар харуулууд 19-24 см бага, Сөгнөгөр голын дагуух Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 22 см бага, Шивэрт голын дагуух Шивэрт-Борнуур харуул 7 см их байна.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хүн бүр гэр бүлдээ ая тухтай, эрүүл энх амьдрах боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 97,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, “Гэр төсөл”-ийн хүрээнд 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр 22 сумын 30 өрхөд өргөө цагаан гэр гардууллаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Эрүүл эхээс- эрүүл хүүхэд” хөтөлбөр батлах тухай” А/184 захирамжаар батлагдсан ажлын хэсгийн анхдугаар хуралдаан зохион байгуулан, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой шийдвэрүүд гарсан.

Иргэн бүрийг “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо”-нд хамруулах үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр ханган ажиллах аймгийн ажлын хэсгийн 2-р хуралдаан зохион байгуулан, үйл ажиллагааны явцын мэдээллийг 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах, ажил эрчимжүүлэх 1 сарын аян зарлах шийдвэрүүдийг гарган, хэрэгжилтийг хангаж байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоог эрчимжүүлэх чиглэлээр 2022.09.27-ны өдөр цахим хурал зохион байгуулан, аймгийн хэмжээнд Засаг даргын А/237 дугаар захирамжаар үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах ажлын хэсгийн гишүүд, 22 сумын Засаг дарга, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд, сумын ЭМТөв, ЕБС, СӨБ-ын удирдлагууд нийт 150 гаруй хүн хамруулан, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр гарсан сарын аяны удирдамжийг танилцуулан, үүрэг чиглэл өгсөн.

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР:

Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургууль дээр Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд 6-р ангийн 28 хүүхдэд “Байр сууриа зөв илэрхийлж сурах, Анги хамт олны дагаж мөрдөх дүрмийг батлах” гэсэн сэдвээр сургалт зохион байгууллаа.

Аймгийн хүүхдийн зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаа явуулах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор өрөөг тохижуулан шинэ элсэлтийн хүүхдүүдээ авч хичээлийн жилийн анхны хурлаа зохион байгууллаа.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын “Хүүхдийн элчийг сонгон ажиллуулах” шинэ журмыг сумдын ЕБС-д хүргүүлэн сурталчилан ажиллалаа.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 25 албан хаагчдад 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр “Гэр бүлийн харилцаа ба хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн үүрэг оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

“Зөв хандлага-Эерэг нөлөө” аяны хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Байгууллагын ёс зүйн зөвлөл, хяналт шинжилгээ үнэлгээ, судалгаа мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнүүд “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр болон Төрийн албан хаагчийн Ёс зүйн дүрэм, МУЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоолоор ажлын байран дээрхи дотоод сургалтыг зохион байгуулж, 14 ажилтныг хамруулсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Төв аймгийн Зуунмод сумын Политехникийн коллежийн 91 оюутнуудад “Өсвөр насны хүүхдийн хүмүүжил, төлөвшил” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Мөн хууль суртчилан таниулах ажлын хүрээнд “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийг QR кодоор дамжуулан оюутнуудад мэдээлэл өгч коллежийн 2 оюутанд сэтгэлзүйн зөвлөгөө өгч ажилласан.

Долоо хоног бүрийн Баасан гарагийн 17:00 цагт “ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЦАГ” мэдээллээр “Хүүхдээ хичээлд явахад нь хэлж болохгүй болон болох зүйлс”, “Хүүхэд сургуульд орсноор тэдний амьдралд ямар өөрчлөлт гардаг вэ?”, “Хүүхдээ бусдыг хүндэлдэг хүн болгон хүмүүжүүлэх аргууд”, “Гэр бүл төлөвлөлт” зэрэг 4 сэдвээр бэлтгэн байгууллагын цахим хаягт байршуулж, иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.

Төв аймгийн Хөдөлмөр Халамж үйлчилгээний газрын санаачлагаар Монголын Удирдлага шинэчлэл менежментийн Академийн дэргэдэх "СОНОР" сургалтын төвийн багш нартай хамтран Хүмүүн цогцолбор сургуулийн 10 дугаар ангийн 167 сурагчдад "Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ?", "Мэргэжил сонгоход юуг анхаарах ёстой", Мэргэжил сонголтын тест гэж юу хэлдэг, яаж таньдаг, ямар ач холбогдолтой болох, "Боловсролын сэтгэл зүйн талаар" сургалт, нөлөөлийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Залуучуудын хөгжлийн төвөөс Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг Төв аймаг дахь салбартай хамтран “Өглөөний клуб”-ын 3 дахь удаагийн арга хэмжээнд Зуунмод сумын

4-р сургуулийн Монгол хэл, бичиг, Уран зохиолын багш Б.Батцэцэг уригдан оролцож Монгол бичгээр КАЛЛИГРАФИ хэрхэн бичиж сурах вэ? өглөөний уулзалт, сургалтыг зохион байгуулан ажиллалаа.

Залуус явуулын үйлчилгээ: Залуучуудад сэтгэл зүйн болон хууль зүйн явуулын зөвлөгөөг үзүүлэх, судалгаа хийх ажлын хүрээнд ГБХЗХГазар, Цагдаагийн газартай хамтран Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 8-12-рангийн сурагчдад "Хүүхдийн хүмүүжил төлөвшил" сэдэвт сургалт, 8-12-р ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчил, цахим дондолт, үе тэнгийн дээрэлхэлтийн талаарх сургалт, 7-р ангийн сурагчдад "Сонголт хийх, шийдвэр гаргах" сэдэвт сургалт, 6-р ангийн сурагчдад " Байр сууриа илэрхийлэх, шийдвэр гаргах" сэдэвт сургалтыг зохион байгуулан ажиллалаа. Мөн сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг 15-18 насны 10 залууд ганцаарчилсан хэлбэрээр үзүүлэн үйлчилсэн.

Төв аймгийн политехник коллежийн 1,2,3 дугаар курсын 91 оюутануудад "Өсвөр насны хүүхдийн хүмүүжил төлөвшил" сэдвээр сургалт зохион байгуулан ажиллалаа.

Ахмад үеийн сайн туршлагыг залуучуудад түгээн дэлгэрүүлэх зорилгоор Төв аймгийн Эрдэнэ сумын иргэн Монгол улсын гавьяат нэгдэлчин, улсын аварга саальчин Пүрэвжавын Чанцалдуламын мал маллагааны арга туршлагыг сурталчилан таниулах арга хэмжээг ГБХЗХГ, Залуучуудын хөгжлийн төв, Эрдэнэ сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГазар, МСҮТөв, Аймгийн баялаг бүтээгчдийн холбоо, Үхэр үржүүлэгчдийн нэгдсэн холбоо зохион байгууллалаа.

Залуучуудын хөгжлийн төвийн санаачлагаар Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газрын хамт олон Батсүмбэр суманд газар тариалан эрхэлдэг "Хүй мандалын андууд" хоршооны тариалангийн талбайд 2 өдөр сайн дураараа туслан "Шинэ цагийн илгээлтийн эзэд" сайн дурын нөлөөллийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулалаа.

Залуучуудын хөгжлийн төвөөс хэрэгжүүлж буй "ӨГЛӨӨНИЙ МЭНД" клубийн гурав дахь удаагийн уулзалтыг Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг Төв аймаг дахь салбартай хамтран "ИОГИЙН ТАЛААР ЗӨВЛӨЛДЬЕ" сэдвээр ярилцаж, иогийн дасгалын ач холбогдол, мэдээллийг хүргэлээ.

Аймгийн залуучуудын холбооны бага чуулган. 2022.09.10 зохиогдон ГБХЗХГазар, аймгийн Залуучуудын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

"Залуучуудын тогтвортой хөгжил корпус"-аас зохион байгуулж буй "Тееп шийдэл" төслийн уралдаанд Хүмүүн цогцолбор сургуулийн сурагчид "Хэрэггүй цаасаа өг" төсөл боловсруулан шилдэг 10-т шалгарсан. Төслийн зорилго хаягдал цаас дахин боловсруулж, төслийн үр дүнг байгаль орчныг хамгаалахад зориулах юм. Аймгийн ГБХЗХГ-ын Залуучуудын хөгжлийн төвөөс төслийн баг, гарах үр дүнг дэмжиж ажиллаж байгаа бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллага, ААН-үүдийг хаягдал цаасаа өгч дэмжиж ажиллах уриалга гаргасан.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХҮРЭЭНД:

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 6 өргөдөл, гомдол, 9 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч ажилласан.

Хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2021 онд шинээр тогтоогдсон болон шилжиж ирсэн 129 хувийн хэргийг шалгаж 19 хувийн хэрэгт баримт бичгийн зөрчил илрүүлэн нөхөн бүрдүүлэлт хийж, баримтын зөрчлийг арилгуулах улсын байцаагчийн албан шаардлага өгч ажилласан. Ажилласан хугацаагаа шүүхээр тогтоолгосон боловч цэргийн алба хаасан хугацаатай давхацсан тул хүнд нөхцлийн тэтгэврийг түдгэлзүүлэн зогсоосон.

Хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Аймгийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн газар, өрхийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн 2020, 2021 оны санхүүгийн баримт, цалингийн баримтад үндэслэн 29 эрүүл мэндийн байгууллагад нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 5 удаа 34 цаг хуралдаж, нийт 229 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 29 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 192 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 18 иргэнийг цуцалсан байна.

Жирэмсэн амаржсаны тэтгэмж 559 даатгуулагчид 944,5 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 932 даатгуулагчид 123,2 сая, ажилгүйдлийн тэтгэмж 251 даатгуулагчид 575,5 сая төгрөг тус тус олгосон байна.

Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан 17347 тэтгэвэр авагчдад 8,3 тэрбум төгрөгийн тэтгэврийг аймгийн хэмжээнд олгон ажилласан.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

2022 оны 9-р сарын байдлаар 1896 иргэнд 4592.8 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1227 иргэнд 914.9 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1077 иргэнд 726.8 сая төгрөгийн амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, 30 иргэнд 36.0 сая төгрөгийн онцгой тохиолдолын мөнгөн тэтгэмж, 9703 эхэд 1249.4 сая төгрөгийн “Алдарт эх” 1, 2-р зэргийн одонтой эхийн мөнгөн тэтгэмж, 5763 ахмад настанд 916.9 сая төгрөгийн насны хишиг тэтгэмж, 1889 ахмад настанд 339.0 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 586 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 98.3 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 5438 иргэнд 410.9 сая төгрөг, жирэмсэн 1447 эхэд 208.7 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4954 эхэд 1750.3 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 319 эх /эцэг/-т 380.9 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 23 ихэр хүүхдэд 46,0 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 4 иргэнд 6,9 сая төгрөг, 34013 хүүхдэд 30467.8 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 125 иргэнд 5,1 сая төгрөгийг тус тус олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын салбар комисс 2 удаа хуралдаж 38 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулав. Шинээр 7 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоож 5 хүүхдийг байнгын асаргаанд хамруулж, 31 хүүхдийн хөгжлийн бэрхшээл, байнгын асаргааг сунгаж ажиллаа.

Байгууллагын харьяалалтай болон харьяалалгүй ахмад настны дэлгэрэнгүй судалгааг авч 19 сумын 7970 ахмадын судалгааг нэгтгэсэн. Олон улсын ахмадын баяраар харьяалалгүй ахмад настанд хүндэтгэл үзүүлэх тухай захирамжийг сумдаас хүлээн авч нэгтгэснээс 12 сумын захирамжаар ирүүлж 1296 ахмадын нэрсийг гаргасан.

Шинээр бий болсон 77 /нийт 681/-н шинэ ажлын байрыг бүртгэн мэдээллийн санд оруулсан. Ажил олгогч аж ахуйн нэгжээс ирүүлсэн 843 сул чөлөөтэй ажлын байранд ажил хайгчаар бүртгүүлсэн 40 иргэнийг зуучилж /нийт 445/ иргэн ажилд зуучлагдлаа. Түр ажлын байранд ажилласан 810 /нийт 6177/ иргэнийг бүртгэж мэдээллийн санг үүсгэн ажиллалаа. Оролцоо төслийн 4-р ээлжийн сургалтад аймгийн 12 залуу хамрагдаж дадлагын ажлаа эхлүүлээд явж байна.

ХАБЭА-н улсын үзлэгийг эрүүл мэндийн салбарт зохион байгуулах удирдамжийг хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хамтран баталж ирүүлсэн. Уг удирдамжийн дагуу аймгийн Засаг дарга ХАБЭА-н улсын үзлэг зохион байгуулах ажлын хэсэг, маршрутыг захирамжаар батлан холбогдох зардлыг шийдвэрлэж өгсний дагуу 10 хүний бүрэлдэхүүнтэй 2 ажлын хэсэг гарч ХАБЭА-н хууль тогтоомжийн хэрэгжилтийг 58 эрүүл мэндийн байгууллагт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт шалгалт хийж, холбогдох сургалт, зөвлөмж чиглэлүүдийг өгсөн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 6 иргэний 19905,1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, өссөн дүнгээр 361 иргэний 356347,7 мянган төгрөг төвлөрсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт өссөн дүнгээр 16 иргэний 76984,2 мянган төгрөг төвлөрсөн. ХЭДСанд 1741778,0 мянган төгрөгийн санхүүжилт ирж тайлант сард 786213,1 мянган төгрөгийг зарцуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн төслийг шалгаруулах аймаг, сумын хамтарсан ажлын хэсгийн нэгдсэн хуралдаанаас 20 иргэнд 118,0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэгдсэн. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт 7 иргэнд нийт 57,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 7 шинэ ажлын байр бий болсон.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Угтаалцайдам, Зуунмод, Сэргэлэн, Баянжаргалан сумын хувиараа хөдөлмөр эрхлэгч 5 ахмадын төсөлд 22,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, тэдгээрийн ажлын байрыг ажилгүйдэлд өртөхөөс сэргийлж хадгаллаа. ХБИХЭДХөтөлбөрийн хүрээнд Бүрэн, Баяндэлгэр, Эрдэнэ, Заамар, Батсүмбэр, Жаргалант зэрэг 6 сумын 10 иргэн төслийн хуралд оролцож, шалгарсан 7 иргэний төсөлд 32,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмжөө сайжруулах боломжийг олгож, 6 иргэний ажлын байр шинээр бий болсон.

ХЭДСангийн санхүүжилтээр бизнесийн үйл ажиллагаа явуулж буй иргэдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах Зуунмод сумын “Төв Керамик” компанийн борлуулалтын цэгт 600,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. ХЭДСангийн хөрөнгөөр бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлж буй 6 сумын 12 иргэний 8,7 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулж, иргэдэд дэмжлэг үзүүлсэн.

Ахмадын ХЭДХөтөлбөрийн хүүхэд хамгаалагч арга хэмжээнд хамтран ажиллаж буй 2 иргэнийг сарын ажлын тайланг хүлээн авч, 560,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авч бизнесийн үйл ажиллагаагаа эхлүүлсэн, үйл ажиллагаа нь тогтвортой бус эрсдэлд орж болзошгүй өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг сургалтаар чадавхижуулах, Ковид -19 цар тахлын дараах үед болон хувийн хэвшилд тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэх гарцыг хэлэлцэх зорилгоор 27 сумын 124 бизнес эрхлэгчдийн хүрээнд “Зөвлөгөөн-сургалт-хэлэлцүүлэг”-ийг цахимаар зохион байгуулсан.

Сургалт зөвлөгөөнд Бизнесээ хөгжүүл 5 модуль сургалтыг Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ-н сургалтын төвтэй хамтран 2 өдөр цахимаар зохион байгуулж, иргэдийн мэдлэгийг дээшлүүлсэн. Мөн шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд бизнес эрхлэгчдэд заавал мэдэх ёстой мэдлэг, шаардлага, үүрэг хариуцлагыг ахмад мэргэжилтэн Эрдэнэдалай танилцуулж зөвлөгөө өгсөн. Иргэдийг 3 бүлэгт хуваан чиглүүлэгчийн удирдлагаар хэлэлцүүлгийг зохион байгуулж, тэдэнд тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэж болох гарцын талаар хэлэлцлээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

Энэ сард аймгийн хэмжээнд 527 төрөлт бүртгэгдсэн. Нийт амьд төрсөн 535 хүүхдийн 6.73% нь 2500 гр-аас доош жинтэй төрсөн. Дархлаажуулалтын хамралт аймгийн хэмжээнд 95.72% байна. 08 дугаар сард хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй. Аймгийн хэмжээнд нийт 721 эмэгтэй жирэмсний хяналтад байна. Нийт 892 жирэмсэн эмэгтэй шинээр хяналтад авснаас эхний 3 сартайд 92.26% байгаа нь улс,аймгийн дунджаас 0.86%-иар өндөр байна. Амбулаторийн нийт үзлэг 217692 байгаа ба урьдчилан сэргийлэх үзлэг 80614 буюу 37.03%, амбулаторийн үзлэг 111318 буюу 51.14% байна.

Стационарт 11829 хүн эмчлэгдэн нийт 86466 ор хоног ашигласан байна. Дундаж ор хоног 7.3 байна. Түргэн тусламжийн дуудлагаар 11515 хүнд үйлчилснээс 25.74% нв алсын, 2.87% нь осол гэмтлийн дуудлага байна. ЭМЯ-с Нэгдсэн эмнэлгийн Дэмжих төвийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний чанарт тусгай шалгуур үзүүлэлтээр хяналт үнэлгээ хийж, газар дээр нь зөвлөн тусалж ажиллалаа.

10-11 дүгээр сард магадлан итгэмжлэлд хамрагдах Эх булаг сувилал, Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн мэдээллийг цахимаар хянаж, ЭМХТөвд цахимаар шилжүүлэн, 12 дугаар сард магадлан итгэмжлэлд хамрагдах Өвөр жанчивлан, Задгай цагаан сувилалд цахимаар зөвлөн тусалсан.

Коронавируст халдвар /Ковид -19/-ын нөхцөл байдал, өвчлөлийн мэдээ, ор хоногийн ашиглалтын мэдээллийг 26 сум, АНЭ-с авч нэгтгэн, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 09 дугаар сард Коронавируст халдвар (Covid-19) – ын 91 тохиолдол батлагдан /Зуунмод сумын 44 тохиолдол/, тандалт судалгаа хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсэн.

Лүн СЭМТөвийн тусламж үйлчилгээтэй холбоотой иргэний гомдлын дагуу ЭМГ-аас 5 хүний бүрэлдэхүүнтэй баг томилогдон ажиллаж, ажил сайжруулах чиглэлээр ЭМГ-ын даргын албан даалгавар хүргүүлсэн.

“Хүүхдийг Ивээх Сан” АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр зохион байгуулагдсан “Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд КОВИД-19 халдварын тохиолдлуудын эмнэлзүйн тусламж үйлчилгээг удирдахуй, Хүчилтөрөгч эмчилгээ” сургалтад аймгийн ЭМГ-ын холбогдох мэргэжилтнүүд, 27 сумын Эрүүл мэндийн төвийн нийт 58 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. Төслийн хаалтын арга хэмжээний үеэр Эрүүл мэндийн сайд, холбогдох яамны удирдлагууд, АНУ-ын Элчин сайдын яамны төлөөлөл, Эрүүл мэндийн төслийн зөвлөх багш нар аймгийн Эрүүл мэндийн салбарт хүчилтөрөгчийн баллон, дагалдах хэрэгслийн хамт гардуулан өгсөн.

ХАБ-ын урьдчилан сэргийлэх улсын үзлэгийг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад МХГ, ХХҮГ-тай хамтран зохион байгуулж, нийт 26 сумын Эрүүл мэндийн төв, 1 ӨЭМТ, АНЭ, хувийн хэвшлийн 15 эрүүл мэндийн байгууллагуудад ХАБЭА-н нөхцөл байдлын үнэлгээ хийж, зөвлөн тусалсан.

ХӨСҮТ-ээс зохион байгуулсан ТТӨ-ий хариу арга хэмжээ, сургамж, туршлагын талаарх үнэлгээ, фокус бүлгийн ярилцлагад аймгийн Засаг даргын орлогч, ЭМГ, АНЭ, ӨЭМТ-удирдлага, мэргэжилтнүүд оролцон, аймгийн хэмжээнд Ковид-19 болон томуугийн дэгдэлтийн үед хэрэгжүүлсэн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний талаар ярилцан, санал солилцлоо.

АШУУИС-ийн 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд багш шавийн уулзалт, сургалт арга хэмжээ зохион байгуулан, 165 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан чадавхижуулсан. Тус арга хэмжээнд Төв аймгийн гаралтай 8 багш хүрэлцэн ирж, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах үндсэн, төрөлжсөн, дээшлүүлэх мэргэжлийн сургалтад 13 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд Хүний эрх, хөдөлмөрлөх эрхийн талаарх сургалт зохион байгууан нийт 125 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрууллаа. 27 сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн даатгалын санхүүжилт авах аргачлал, эх, хүүхдийн тусламж үйлчилгээ сайжруулах чиглэлээр цахим хурал, Эх, хүүхдийн Эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран Жирэмслэлт ба хавдар”, “Цочмог эндокардит”, “Умайн хүзүүний эрт илрүүлэг” сэдэвт цахим сургалт тус тус зохион байгуулж, нийт 132 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа.

Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал үндэсний хэмжээний сургалтад аймгийн 5 төлөөлөл оролцож, цаашид гамшгийн үед хүүхэд хамгааллын чиглэлээр хийх ажлаа төлөвлөсөн. Баянхангай, Баянцагаан сумдад ОБГ-тай хамтран Гамшгийн үеийн бэлэн байдлын сургалт, дадлагад сумын ЭМТ-г зохион байгуулан, амжилттай оролцсон.

Эрүүл мэндийн газрын Алхалтын клуб, Залуучуудын зөвлөлтэй хамтран “Алхалт үнэ цэнийг бүтээнэ” алхалтын арга хэмжээ зохион байгуулж, оролцогчдод Дасгал хөдөлгөөний ач тус, эрүүл зөв хооллолтыг сурталчиллаа.

Баян-Өнжүүл суманд ЭМГ, АНЭ-ийн хамтарсан зөвлөн туслах баг ажиллаж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулан, 50 гаруй иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан.

Эх хүүхдийн Эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг хамтран “0-3 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг” сэдэвт онол, дадлага хосолсон сургалт зохион байгуулан, 26 сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн нийт 50 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан, гарын авлага, видео хичээлүүд тараалаа.

Зуунмод сумын 6 багийн Иргэдийн нийтийн хуралд оролцож урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэгийн зохион байгуулалт, ач холбогдол, архи тамхины хор уршиг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлээр нийт 745 иргэдэд мэдээлэл хийсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрүүл ахуй, халдвар хамгаалалын дэглэмийн мөрдөлтөд тандалт хийж, нийт 500 арчдас шинжилгээний сорьц цуглуулж, орчны эрүүл мэндийн лабораторид шинжилгээ хийгдэж байна.

Тууралтат халдвар, гэдэсний халдварын нийт 10 тохиолдолд тандалт судалгаа хийж, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсэн. Гар хөл ам, гэдэсний халдварт өвчний голомтын халдваргүйтгэлийг 235 мкв талбайд хийж гүйцэтгэсэн. Баянчандмань суманд бүртгэгдсэн Хүний боом өвчний мэдээллийн дагуу ЭМГ-аас 3-хүний бүрэлдэхүүнтэй баг томилогдон хавьтлын тандалт судлагаа хийж, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн тайлан мэдээг ЗӨСҮТ-д хүргүүлсэн.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

ЭМДЕГазартай гэрээт Төв аймгийн 46 Эрүүл мэндийн байгууллагуудаас 08 дугаар сарын 01-31-ний өдөр хүртэл эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн 15587 иргэний 1,1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн нэхэмжлэхэд хяналт хийж, 922 иргэний 76,5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 14665 иргэний 992 сая төгрөгийн гүйцэтгэлийг ЭМБ-уудад олгохоор ЭМДЕГ-т хүргүүлж, нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн алдаа зөрчийг хасагдсан шалтгаанаар нь нарийвчлан гаргаж ЭМБ-дад хүргүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэст хандсан нийт 22 иргэнд ЭМД-н тухай хуулийн өөрчлөлт шинэчлэлт, ЭМД шимтгэл төлөлт, өндөр өртөгтэй оношлогоо шинжилгээ, эрт илрүүлгийн талаарх мэдээллийг хүргэсэн.

Зуунмод сумын 6-р багийн Иргэдийн нийтийн хуралд “Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол” сэдэвт сургалтыг 99 иргэнд хийж, иргэдийн асуултад хариулт өгч ажилсан.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Төв аймгийн “БАГШИЙН ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИЛ-ЗӨВЛӨХ БАГШ НАРЫН МАНЛАЙЛАЛ” сургалт, зөвлөгөөнийг 08 дугаар сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулав. Боловсролын тэргүүний ажилтнууд болон ЭШШалтгалтнд тэргүүлсэн багш нар, сурагчдыг шагнаж урамшуулав.

Төв аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Зуунмод сумын Тамгын газартай хамтран 2022 оны 8 сарын 30-ны өдөр Зуунмод сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд хичээлийн жилийн бэлтгэл ажлын хэрэгжилт, өвөлжилтийн бэлтгэл байдлыг шалгав.

Хичээлийн шинэ жилийн нээлтэд Газрын дарга болон мэргэжилтнүүд оролцов. Хичээлийн шинэ жилийн нээлтэд тухайн сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нараар Чингис хааны эш хөргийг Төв аймгийн төрийн өмчийн 31 Ерөнхий боловсролын сургууль, 37 цэцэрлэгүүдэд залах ажлыг зохион байгуулж ажиллав.

Төв аймгийн Зуунмод 4 дүгээр сургуулийн нээлтийн үйл ажиллагаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны сайд хүрэлцэн ирэв. Үүнтэй холбогдуулан зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж ажиллав.

Төв аймгийн Алтанбулаг суманд 09 сарын 09-ний өдөр “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулав. Тус өдөрлөгийн хүрээнд Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багш, сурган хүмүүжүүлэгч нарт судлагдахуун бүрээр хичээлд сууж зөвлөн туслах, эцэг, эх, асран хамгаалагч нарт сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгааг хэрхэн зохион байгуулах, цахим элсэлт, шилжилт, боловсролын бичиг баримт нөхөн олгох, Үдийн хоол хөтөлбөр, хөрөнгө оруулалт, хүүхэд хамгаалал, эрсдлээс сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, судалгаа авах ажлыг хийж гүйцэтгэв.

Судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд судлагдахуун тус бүрээр “Мэргэжлийн хөгжлийн бүлгийн ажиллах аргачлал”, “Багшийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” сэдвээр цахимаар судлагдахуун бүрээр сургалт явуулав.

2022-2023 оны хичээлийн жилийн I-V-р ангийн сурах бичгийн түгээлтийн хуваарийг гаргаж, Ерөнхий боловсролын сургуулиудад сурах бичгийн түгээлт явагдаж байна. Төв аймгийн Баянхангай, Лүн, Алтанбулаг сумдад боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ, арга зүй, технологи, суралцагчийн эрх, хамгаалал, хөгжил, төлөвшил, тэгш хамран сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, цахим шилжилт, сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багш, удирдах ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтийг энэ чиглэлийн мэдээллээр ханган, дэмжлэг үзүүлж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав.

Багш, удирдах ажилтны насан туршийн боловсрол цахим уулзалтад Насан туршийн боловсролын удирдах ажилтан, багш нар хамрагдлаа. Бичиг үсгийн боловсрол олгох сургалтын ШШГГ-ын хүсэлтээр ганцаарчилсан сургалтыг мягмар, пүрэв гарагт нэг хүмүүжигчид зохион байгуулж байна. Тус хүмүүжигч үсэг таних чадвартай бөгөөд унших, бичих дасгал ажил ажиллаж байна.

“ӨВ СОЁЛОО ЭРХЭМЛЭЖ ҮНДЭСНИЙ БИЧГЭЭ СУРЦГААЯ- 2025” аяны хүрээнд аймгийн хэмжээнд үндэсний бичгээ сурах аян өрнүүлж монгол хэл бичгийн сургалтыг Боловсрол шинжлэх ухааны газар 18 албан хаагч, Соёл урлагийн газар 5 албан хаагч, Насан туршийн боловсрол 3 албан хаагч, Туургатан театр 52 албан хаагч, Номын сан, Спортын хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт зохион байгуулж байна. Хүний нөөцийн судалгаа, Бичиг үсэг үл мэдэгчийн судалгаа, 2022-2023 оны боловсрол нөхөн олгох суралцагсдын судалгааг шинэчлэн авч байна.

“ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ” Улаанбаатар хотод зохион байгуулагдаж байна. 2022 оны 09 дүгээр сарын 28, 29-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус сургалт нь Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Гэр бүл бодлогын хэрэгжилтийн газар, Боловсролын ерөнхий газрын Насан туршийн боловсролын хэлтэс хамтран зохион байгуулж байна. Уг сургалтад Төв аймгийн Шижир-Алт сумын Заамар хоёрдугаар сургуулийн насан туршийн боловсролын багш Г. Хишигжаргал хамрагдлаа.

Нэгжийн багш нарыг сургагч багш нараар бэлтгэх, “Малчдын амьдрах ухааны боловсролыг дэмжих” сургалтыг 2022 оны 09-р сарын 29-ны өдөр Төв аймгийн Баянцогт сумын насан туршийн боловсролын багш Б. Баасандулам, Баян-өнжүүл сумын насан туршийн боловсролын багш Р. Баянзул нар сургагч багш нар нэгжийн насан туршийн боловсролын багш нарт зохион байгууллаа.

СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллогын ажлыг 27 суманд 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлүүллээ. Энэхүү тооллогоор аймгийн хэмжээнд нийт 27 сумын 468 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын 5665 дурсгал тооллогдох болно.

Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан Алтанбулаг суманд соёл, урлагийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд “Соёлын орон зай” арга хэмжээг хандлагаа өөрчлөө, хамтдаа бүтээцгээе уриан дор зохион байгуулж МТТ, ННС, Музейн албан хаагчид хамтран нийгэмд тустай ажлын хүрээнд Алтанбулаг сумын “Туул” голын эрэг дагуух хогийг цэвэрлэх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн “Соёл, урлагийн ажилтны баярын өдөр”-ийг 09 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Монгол улсын Соёлын яамнаас 18,2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж сумдын соёлын төвийн номын сан болон аймгийн ННС-нд хүүхдийн номын сан хөмрөгийн баяжилт хийгдэхээр шилжүүллээ. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралт сумдын хамгаалтад авах ТСҮХДГ-ын жагсаалтыг хэлэлцүүллээ.

Аймгийн Нийтийн номын сан нь 2022 оны 9 сард танхимаар **138-н** байнгын уншигч, **860** ирэгсэд, нийт **2360** уншигчдад ном олгож уншуулан үйлчилсэн байна. Нийт **138** уншигч шинээр карт нээлгэснээс **56** эрэгтэй, **82** эмэгтэй уншигч байна. Гэрээр ном олгох танхимаар 13 уншигчидад 45 номоор үйлчилсэн. Нийтийн номын санд төсвөөр 305 ширхэг 5.758.798 төгрөгийн ном, хандиваар 12 ширхэг 280.000 төгрөгийн ном нийт **317** ширхэг **6.038.798** төгрөгийн номыг нэгбүрчилсэн бүртгэл болон электрон каталогит оруулж уншигчдын хүртээл болгоод байна.

Нийтийн номын сангийн Уншлагын 3-н танхимд “Эх хэлний өдөр”-ийг тохиолдуулан “Эх хэл бидний бахархал” сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 215 номоор гаргаж нийт 85 уншигчдын хүртээл болгосон.

Пөнтэк хотын Дарга Жон Жансон тэргүүтэй зочид Нийтийн номын сангийн засвар шинэчлэл, БНСУ-ын Пөнтэк хотын нэрэмжит цахим мэдээллийн танхимтай танилцаж хоёр номын сангийн удирдлагууд “Санамж бичиг”-т гарын үсэг зуран хамтран ажиллахаар боллоо. Миний гэр бүл гар зургийн уралдаанд бүтээлээ илгээсэн Зуунмод хотын авъяаслаг хүүхэд багачуудад дурсгалын зүйл гардууллаа.

Үндэсний бичиг соёл, номын баярыг угтан “**Зохиолч уншигчдын уулзалт**”-ыг зохион байгуулж уулзалтын зочидоор Д.Нацагдоржийн болон МЗЭ-ийн шагналт зохиолч сэтгүүлч Шинжлэх ухааны тэргүүний ажилтан, судлаач, Соёлын гавъяат зүтгэлтэн Шагдарсүрэнгийн Цэрэндоо, Д.Нацагдоржийн болон МЗЭ-ийн шагналт зохиолч, Ардын боловсролын тэргүүний ажилтан, сэтгүүлч Шаравын Бадарч, Д.Нацагдоржийн болон МЗЭ-ийн шагналт зохиолч яруу найрагч Оюунбадамын Сундуй нар оролцлоо. Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдгээр Алтанбулаг сумын ЕБС-ын 12а ангийн сурагч Г.Мөнхжин, Цээл сумын ЕБС-ын 12а ангийн сурагч Б.Саруул нар шагнагдлаа. Нийт 66 уншигч, иргэд хамрагдсан.

“**ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД**” 32 дахь удаагийн номын баярыг Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор “**ИЛҮҮ ИХ УНШЪЯ**” уриатайгаар нээлтийн арга хэмжээг 09-р сарын 16-ны өдөр 11:30-16:30 цагт аймгийн төвийн Зуунмод сумын “Монгол Туургатан театр” -т зохион байгуулж нээлтийн арга хэмжээнд аймгийн УИХ-ын гишүүн Н.Энхболд, БНСУ-ын Пөнтэк хотын дарга Жан Жон Сон болон албаны бусад хүмүүс оролцлоо.

Номын баяраар Нийтийн номын сангаас “**Үлгэрийн баатрууд эргэж ирсэн нь**” Маск Парад дүрийн тоглолтыг Зуунмод сумын төрийн байгууллага болон ЕБС-ын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдын 136 албан хаагч болон сурагчид хамрагдсан. “Хорин номын хожил”, “Уншсан номоо нэрлээрэй” асуулт хариултын тэмцээн, “Зөөврийн номын сангийн үйлчилгээ”, “Шинэ номын худалдаа”, “Монгол өв соёл-Бидний бахархал” номын үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийт 300 гаруй иргэн хамрагдсан.

Ном солилцоо, номын хандивын аяны хүрээнд иргэн Нарантуяа, “Хүмүүн цогцолбор” ахлах сургуулийн “**Номын андууд**” клубын сурагчид үйл ажиллагаагаа сурталчилан идэвхтэй оролцож 50 номын хандив өргөснийг Төв аймаг дахь ШШГГазарт оюуны хөрөнгө оруулалт болгон хандивлалаа.

Нийтийн номын сангаас “**Үлгэрийн баатрууд амилсан нь**” тэмцээнийг Зуунмод сумын 6 цэцэрлэгийн 36 хүүхэд багачуудын дунд зохион байгуулж, амжилттай явагдаж дууслаа. Үүнд: Тэргүүн байранд: Хүмүүн цэцэрлэгийн “Монгол Ухаан” баг, Дэд байранд Бүжинхэн А байрны “Арга Билиг” баг, Гутгаар байранд Ирээдүй Б байр “Үлгэрч” багууд тус тус шалгарч өргөмжлөл, медаль, дурсгалын зүйлээр шагналаа.

“Зөв хандлага-Эерэг нөлөө” аяны хүрээнд Нийтийн номын сангийн албан хаагчдын дунд зарласан “Онч мэргэн үгс”-ийн уралдаанд оролцогчдын бүтээлийг цувралаар хүргэж байна. “Цахим мэдээллийн танхим”-аас уншигч хүүхэд залуучууд, иргэдэд зориулан Номын сангийн үйл ажиллагаа, цахим сан хөмрөгөөс сурагчдын заавал унших ном, үлгэр болон мэдээ мэдээлэлийг Нийтийн номын сангийн Facebook page цахим хуудсанд **67-н** мэдээ мэдээллийг байршуулан олны хүртээл болгож **19,324** хандалт авсан байна

Аймгийн Монгол Туургатан театр дотоод арга хэмжээ 6, гадны арга хэмжээ 8 нийт 14 арга хэмжээнүүд зохион байгуулагдаж 5200 хүнд үйлчилсэн байна. Панфилова Рыжковагийн зохиол **“ШИВШЛЭГТЭЙ ЗУРГИЙН НУУЦ”** хүүхдийн жүжгээ Налайх дүүрэг, Өлзийт хорооллын хүүхэд багачуудад тоглолоо. Манзушир дахь түүх соёлын дурсгалт газарт **“МАНЗУШИР АРТ”** ардын урлагийн тоглолт, Панфилова Рыжковагийн зохиол **“ ШИВШЛЭГТЭЙ ЗУРГИЙН НУУЦ ”** хүүхдийн жүжгийг жуулчдад тоглолоо.

Аймгийн Музейгээр 9-р сард нийт 5791 иргэн үйлчлүүлсэн бөгөөд үүнээс хүүхэд 4894, том хүн -900 үйлчлүүлсэн байна.

Үндэсний номын баярын 32 дахь удаагийн арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаа Монгол туургатан театрт болж, аймгийн музейгээс 2 ажил зохион байгуулж оролцлоо. Ном хэвлэлийн холбогдолтой үзмэрээр “Соёлын өв” нүүдлийн үзэсгэлэн гаргаж, БНСУ-ын Пёнтек хотын дарга Жон Жансон тэргүүтэй зочид төлөөлөгчид болон төрийн албан хаагч, Зуумод сумын ЕБС-ын багш, сурагчдад мэдээлэл, тайлбар хийж өгсөн. Мөн Үндэсний бичгээ хэн сайн мэдэх вэ? танин мэдэхүйн “Алтан хонх” тэмцээнийг иргэдийн дунд 2 удаа зохион явуулж, 20 иргэн оролцож түрүүлсэн иргэдийг үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан.

Монголын Угсаатан судлал -2022 Олон улсын эрдэм шинжилгээний II хуралд Музейн арга зүйч С.Сувдаа, Эрдэм шинжилгээний ажилтан Ц.Цэцэгжаргал нар “Төв аймаг дахь Казахуудын соёлын харилцааны өнөөгийн байдал” сэдвээр илтгэл бичиж оролцсон.

Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын 2022 оны А/14 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан ТСҮХД-ын улсын тооллогыг зохион байгуулах удирдамж, Аймгийн Засаг даргын 2022 оны 08-р сарын 23-ны өдрийн А/484 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг сум орон нутагт ТСҮХД-ын улсын тооллогын ажлыг эхлүүлээд байна. Манзушир дахь Байгалийн музейн голын модон явган хүний замыг 621000 төгрөг зарцуулж музейн ажиллагсад засварласан.

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Төв аймгийн Баян-Өнжүүл суманд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Сөдөтийн шагайн тойром харваа сэргэж харвасны 21 жилийн ойн нэрэмжит тойром харвааг 2022 оны 09-р сарын 03-04-ны өдрүүдэд Баян-Өнжүүл суманд зохион байгуулж 8 аймгийн 28 багийн 196 харваач оролцлоо.

Зуунмод кап-2022 ахмадын граунд гольфийн нээлттэй тэмцээн 2022.09.14-нд зохион байгуулж 5 аймаг, 2 клуб, УБ хотын 5 дүүргийн 162 тамирчин 60-аас дээш доош гэсэн насны ангилалаар өрсөлдлөө.

Зуунмод сум үүсгэн байгуулагдсаны түүхт 80-н жилийн ойн нэрэмжит 2022 оны дугуйт цанын улсын аварга шалгаруулах тэмцээн 2022.09.21-23-ны өдрүүдэд Зуунмод суманд амжилттай зохион байгуулагдан 13 байгууллагын 73 тамирчин оролцож Төв аймгийн баг тамирчид 9 алт, 4 мөнгө, 1 хүрэл медал хүртэж тэргүүллээ.

2022 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу хөлбөмбөгийн хүүхдийн лигийн тэмцээн буюу “Гоолын баяр-2022” арга хэмжээг 2022.09.10-25-ны өдрүүдэд зохион байгуулан явуулж 250 гаруй сурагчдыг хамрууллаа.

Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын ажилчин албан хаагчидтай хамтран дугуйтай аялалыг 2022.09.03-нд зохион байгуулж 28 албан хаагчийг хамруулсан.

Ахмад багш, Ардын боловсролын тэргүүний ажилтан, Биеийн тамирын тэргүүний ажилтан Н.Аюу агсны нэрэмжит “Сэлэнгэ цом-2022” кросс гүйлтийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2022.09.12-13-нд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотноо зохион байгуулагдаж манай баг тамирчид 2 алт, 3 мөнгө, 5 хүрэл хүртэн багийн дүнгээр 3-р байрыг эзэллээ.

ОХУлсад зохион байгуулагдсан “BAIKAL PRO-2022” жюүжицүгийн "Олон улсын" тэмцээнд манай тамирчид амжилттай оролцож 5 алт 1 мөнгө 1 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 5-р байрыг эзэллээ.

Монголын Бүх ард түмний XV их наадмын шигшээ тэмцээнүүд 2022.09.05-18-ны өдрүүдэд зохион байгуулагдан энэ удаагийн наадамд Төв аймаг спортын 23 төрлөөр 185 тамирчинг оролцуулж 1 алт, 2 мөнгө, 7 хүрэл медаль хүртлээ.

НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:

2022 оны 9 дүгээр сарын 09-нөөс 5 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлтэй хамтран орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй сургалтыг Цагдаа газар болон, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлтэй хамтран зохион явуулсан.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР